



**МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ**

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН  
2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН  
2021 ОНЫ ЭНХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**1. Компанийн танилцуулга**

- 1.1 Компанийн тухай товч мэдээлэл
- 1.2 Дүрмийн сан, түүний өөрчлөлт, хувьцаа эзэмшилт
- 1.3 Компанийн үйл ажиллагаан дахь төрийн оролцоо, нөлөөлөл
- 1.4 Бүтэц зохион байгуулалт, удирдлага

**2. Компанийн засаглалын үйл ажиллагаа:**

- 2.1 Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд
  - 2.1.1 Ил тод байдал
  - 2.1.2 Үүргийн хариуцлага
  - 2.1.3 Тайлагналын хариуцлага

**3. Захиргаа, удирдлагын үйл ажиллагааны хүрээнд:**

- 3.1 Үйл ажиллагааны төлөвлөлт
- 3.2 Хүний нөөцийн удирдлага
- 3.3 Архив, албан хэрэг хөтлөлт
- 3.4 Хууль, эрх зүй
- 3.5 Гадаад харилцаа
- 3.6 Олон нийтийн харилцаа, маркетинг
- 3.7 Мэдээлэл технологи

**4. Санхүүгийн ажлын хүрээнд:**

- 4.1 Зардлын үзүүлэлт
- 4.2 Орлогын үзүүлэлт

**5. Инженер, технологийн үйл ажиллагааны хүрээнд:**

- 5.1 Инженер, технологийн үйл ажиллагаа
  - 5.1.1 Хөдлөх бүрэлдэхүүний парк
- 5.2 Хөдлөх бүрэлдэхүүний түрээсийн талаар судалгаа
- 5.3 Хөдлөх бүрэлдэхүүний засвар, ашиглалт
  - 5.3.1 Зүтгүүрийн аж ахуйн чиглэлээр
  - 5.3.2 Вагоны аж ахуйн чиглэлээр
  - 5.3.3 Зам засварын машин механизмын чиглэлээр
- 5.4 Суурь бүтцийн чиглэлээр үйл ажиллагаа

**6. Шинэ төмөр зам төслийн хүрээнд:**

- 6.1 Төслийн хураангуй
- 6.2 Эрх зүйн үндэслэл
- 6.3 Хөрөнгө оруулалт
  - 6.3.1 Монгол улсын засгийн газрын зүгээс оруулах хөрөнгө оруулалт
  - 6.3.2 Өөрийн хөрөнгө оруулалтын санхүүжилт
- 6.4 Суурь бүтэц барих чиглэлээр хийгдэж буй ажлууд
  - 6.4.1 “Тавантолгой – Гашуунсухайт” чиглэлийн төмөр зам

- 6.4.2 Зүүн босоо коридор “Чойбалсан- Хөөт-Бичигт” чиглэллийн төмөр зам
- 6.4.3 “Зүүнбаян –Ханги”
- 6.4.4 “Зүүнбаян - Ханги” чиглэлийн төмөр зам
- 6.4.5 “Сайншанд – Хөөт” чиглэлийн төмөр зам
- 6.4.6 “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр зам
- 6.4.7 Бусад

6.5 Зөвшөөрлүүд, Байгаль орчин, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Орон нутгийн харилцаа

- 6.5.1 Байгаль орчны менежментийн чиглэлээр
- 6.5.2 Орон нутгийн харилцааны чиглэлээр
- 6.5.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр / ХАБЭА/

**7. Стандартын төсөл боловсруулах ажил**

**8. Тээвэр зохион байгуулалтын ажлын хүрээнд**

**9. Тяньжин тээвэр ложистик төв төсөл**

- 9.1 Төслийн хураангуй
- 9.2 Төслийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын асуудал

**10. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ГАЗАР**

- 1. Төмөртэй өртөөний тээврийн үйл ажиллагаанд тавих хяналт, урьдчилан сэргийлэх шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх чиглэлээр
- 2. Төслийн гүйцэтгэл, түүнд тавих хяналт чиглэлээр
- 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны чиглэлээр
- 4. Хяналт, шинжилгээ, үнэлгээний чиглэлээр

**11. Дүгнэлт**

## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 1. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Алсын хараа:

“Дэлхийд тэргүүлэгч төмөр замын тээвэрлэгч болох”

Эрхэм зорилго:

“Монгол улсын төмөр замын салбарын хөгжлийг тодорхойлогч үндэсний компани байх”

Зорилт:

- Компанийн тогтвортой хөгжлийг хангах
- Санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах механизмыг бүрдүүлэх
- Идэвхтэй инновацийн системийг бүрдүүлэх
- Хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэх
- Компанийн засаглалыг сайжруулах:
- Эрсдлийн удирдлагыг боловсронгуй болгох
- Санхүүгийн тунгалаг байдлыг хангах
- Бүтээмжийг дээшлүүлэх
- Зах зээлийн таатай орчин бүрдүүлэх
- Салбарын хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход идэвхтэй үйл ажиллагаа явуулах, оролцох
- Төмөр замын тээврийн зах зээл дэх байр сууриа тэлж өргөжүүлэх замаар ашиг, орлогын түвшинг дээшлүүлэх
- Оновчтой, өндөр өгөөжтэй төсөл боловсруулан хөрөнгө оруулалтуудыг татах

#### 1.1 Компанийн тухай товч мэдээлэл

Үндсэн үйл ажиллагааны чиглэл:

- Төмөр замын суурь бүтэц барих, ашиглах, арчлах;
- Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх;
- Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, түрээслэх, засварлах;
- Гадаад худалдаа, хуулиар хориглоогүй бизнес эрхлэх.

#### 1.2 Дүрмийн сан, түүний өөрчлөлт, хувьцаа эзэмшилт

“Монголын төмөр зам” ТӨХК нь нэг бүрийн 100 /Нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 207,277,000 /Хоёр зуун долоон сая хоёр зуун далан долоон мянга/ ширхэг энгийн хувьцаатай, 100 хувийн төрийн өмчит хувьцаат компани юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн хууль, Засгийн газрын 2016 оны 35 дугаар тогтоолын хүрээнд компанийн хувьцаа эзэмшигч нь Засгийн газраас эрх олгосны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар юм.

#### 1.3 Компанийн үйл ажиллагаан дахь төрийн оролцоо, нөлөөлөл

Компанийн үйл ажиллагаа нь “Компанийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль” болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу зохицуулагддаг.

Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 121 дүгээр тогтоолоор улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдол бүхий төмөр замын суурь бүтцийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар цогцоор нь барьж байгуулах нь зүйтэй гэж

үзэн “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-т заасан I, II дахь үе шатны төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон.

Монгол Улсын Засгийн газраас “Монголын төмөр зам” ТӨХК-д төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгосны хувьд түүний хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй бөгөөд энэхүү хүчин зүйл нь “Монголын төмөр зам” ТӨХК дахь төрийн оролцоо, нөлөөллийн хэмжээг тодорхойлдог.

#### 1.4 Бүтэц зохион байгуулалт, удирдлага

Хувьцаа эзэмшигчийн чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна. ТУЗ-тэй байгуулсан Контракт гэрээгээр олгосон эрх хэмжээний дотор Гүйцэтгэх захирал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар ханган ажилладаг. “МТЗ” ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 18 дугаар тогтоолоор баталсан бүтэц, орон тооны хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

## 2. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

Компанийн засаглалын зорилт нь Гүйцэтгэх удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөл, Хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын хоорондын харилцааг сайжруулж төгөлдөржүүлэхэд оршино.

### 2.1 Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын, Аудитын хороод байгуулагдан хуульд тусгагдсан эрх, үүргийн хүрээнд ажиллаж байна.

Компанийн сайн засаглалын чухал үзүүлэлт болох дотоод хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий дотоод аудитын нэгжийг Гүйцэтгэх захирлын дэргэд байнгын ажиллагаатайгаар бүтцэд оруулан батлуулж компанийн үйл ажиллагаанд хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

#### 2.1.1 Ил тод байдал

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль”-д заасны дагуу компанийн санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлтүүд, өмч хөрөнгийн болон удирдлагын бүтэц зохион байгуулалт, тендер худалдан авалттай холбоотой мэдээллийг цаг тухайд нь нийтэд мэдээллэн ажиллаж байна.

Хөрөнгийн бирж болон компанийн цахим санд Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын шийдвэр, компанийн санхүүгийн тайлан болон бусад шаардлагатай мэдээллийг тогтмол байршуулж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

#### 2.1.2 Үүргийн хариуцлага

Компанийн үйл ажиллагааны дотоод болон хөндлөнгийн хяналтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, компанийн удирдлагын тогтолцоо, бүтцийг олон улсын жишигт нийцүүлэх, улмаар удирдлагын түвшинд хараат бус гишүүдийг оролцуулж төрийн төлөөлөлд хяналт тавих, ТУЗ-ийн дэргэд хороод ажиллуулснаар ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, ТУЗ нь хороодын үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлэх зарчмаар оновчтой бүтцээр зохистой хяналтыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржтэй ажил хэргийн байнгын харилцаатай байж мэдээлэл солилцох, авлигын эсрэг үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй ажиллагааны хүрээнд АТГ болон ТЕГ-тай хамтран ажиллаж байна.

Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2009 оны 143, 2013 оны 411 дүгээр тогтоол, 2016 оны 38 дугаар тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505, 2014 оны 162 дугаар тогтоол Зам, тээврийн

хөгжлийн сайдын 2017 оны 89 тоот тушаал болон бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж байна.

### 2.1.3 Тайлагналын хариуцлага

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2013 оны 322 тоот тогтоолын “Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 109 тоот тушаалын дагуу МТЗ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/32 тоот тушаал гаргаж, тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд танилцуулах тайлан, мэдээг тогтоосон хугацаанд мэдээллэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн ажлын явц, шийдвэрийн хэрэгжилт, цалин зардлын тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тухай бүр танилцуулж ажиллалаа. Мөн компанийн 2020 оны санхүү, эдийн засаг, удирдлагын үйл ажиллагаанд “**Үндэсний аудитын газар**” аудитыг гүйцэтгэсэн. Аудитаас гарсан зөвлөмжийн дагуу хяналтын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтээлч, үр ашигтай хяналт, мониторингоор хангуулах талаар идэвхи санаачлагатайгаар ажиллаж байна.

## 1. ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 3.1 Үйл ажиллагааны төлөвлөлт

Компанийн дотоод зохион байгуулалт, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртэй уялдуулан холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн найруулсан ба 2021 оны Зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөл, Хувьцаа эзэмшигчийн хурлаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

### 3.2 Хүний нөөцийн удирдлага

**Ажлын бүтээмж:** Ажлын цаг ашиглалт, бүтээмжийг дээшлүүлэх үүднээс ажилтан долоо хоног бүр тайлан, төлөвлөгөө гаргахаар журамласан бөгөөд жилд 2 удаа буюу хагас жил, бүтэн жилийн тайланг авч ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлдэг ба ирцийн тайланг тухайн сар бүр 2 удаа гаргаж, цагийн бүртгэлтэй тулгалт хийн, санхүүгийн тооцоо нийлж, ажилтны хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хариуцлагыг өндөржүүлж байна.

**Хүний нөөцийн мэдээллийн сан:** Компанийн нийт ажилтнуудын хувийн хэргийн мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэн, боловсронгуй болгож, мэдээллийн бааз бий болгон Хүний нөөцийн программыг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд энэхүү программ нь механик ажиллагааг багасгах, зардал болон ажлын цагийг хэмнэх төдийгүй ажилтнуудын ажилласан жил, зэргийн нэмэгдэл, шилжилт хөдөлгөөн, боловсролын зэрэг, мэргэшлийн зэрэг, хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийн санг бүрдүүлэх ач холбогдолтой. Мөн программд өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлт, чөлөө, ээлжийн амралт, сахилгын шийтгэл, гавьяа шагнал, урамшуулал, сургалтын болон бусад мэдээллийн талаар өдөр тутам бүртгэлжүүлэн ажиллаж байна.

**Компанийн хөдөлмөрийн харилцааг удирдан зохион байгуулах ажлын хүрээнд:** 2021 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн харилцаатай холбоотой 362 тушаалын төсөл боловсруулан албажуулсан.

Үүнд:

- Ажилд томилох тухай – 76
- Түр томилох тухай – 63
- Шилжүүлэн томилох тухай – 43
- Ажлаас халах тухай – 14
- Сахилгын шийтгэл ногдуулах тухай - 6
- Ажлаас чөлөөлөх тухай – 48
- Тусламж, дэмжлэг үзүүлэх тухай – 15
- Чөлөө олгох тухай – 31
- Ээлжийн амралтаас дуудан ажиллуулах тухай – 16
- Жирэмсний амралт олгох тухай – 5

- Бусад – 2.

Мөн ажилтнаас ирүүлсэн 14 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлүүлэн, зохих арга хэмжээг авч ажилласан.

**Сонгон шалгаруулалт:** 2021 оны жилийн эцсийн байдлаар үндсэн хөдөлмөрийн гэрээт 225 ажилтан ажиллаж байгаагаас төв ажлын байранд 156, “Төмөртэй өртөө”-нд 89, хөлсөөр ажиллуулах гэрээт 76 нийт 301 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Сонгон шалгаруулалтыг Монгол улсын хөдөлмөрийн төв бирж, Их дээд сургуулиуд, мэргэжлийн холбоодтой харилцаа тогтоож холбогдох хууль, дүрэм журмын дагуу нээлттэйгээр зохион байгуулдаг бөгөөд компанийн [www.mtz.mn](http://www.mtz.mn) сайт, пэйж хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр нээлттэй ажлын байрны зарыг байршуулан ажилласан.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслийн хүрээнд Өмнөговь аймгийн Манлай, Цогтцэций, Дорноговь аймгийн Мандах, Сайншанд сумдын болон бусад аймаг орон нутгаас нийт 69 иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байна. Мөн Зүүнбаянд байгуулагдах Замын ангид шаардлагатай ажилчдыг орон нутгаас хангах хүрээнд Дорноговь аймгийн Засаг даргын тамгийн газартай хамтран орон нутгийн ажилгүй иргэдийн дунд судалгаа явуулж, урьдчилсан байдлаар 15 иргэний ажлын байраар хангасан бөгөөд цаашид төмөр замын мэргэжилтэй ажилчин бэлтгэх чиглэлд хамтран ажиллаж байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр сургалтын үндэсний төв”, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо” зэрэг байгууллагуудтай нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх үүргийн хүрээнд хамтран ажиллаж, орон нутгаас /Өмнөговь-1, Дорноговь-2/ хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэнийг ажлын байраар ханган ажилласан.

### 3.3 Архив, албан хэрэг хөтлөлт

2021 оны байдлаар гадагш явуулсан нийт 1587 албан бичиг үүнээс хариу авах шаардлагагүй албан бичиг нийт 1089, хариу ирэх албан бичиг нийт 498 бүртгэгдсэн байна. Байгууллагад ирсэн албан тоот нийт 1704 бүртгэгдэж, үүнээс хариу явуулсан 603, танилцаж, шийдвэрлэсэн 1101 албан тоот бүртгэгдсэн бөгөөд албан хэрэг хөтлөлтийг хуулийн хүрээнд явуулж байна.

Байгууллагын архивын нийт 2356 хадгаламжийн нэгжийг цаг тухайд нь компанийн ажиллагсад болон аудитын байгууллагын ажиллагсад давхардсан тоогоор 62 хүнд танилцуулж, хуулбар олгож, лавлагаа өгч холбогдох мэдээллээр хангаж хамтран ажиллалаа. Архивын хадгаламжийн нэгж бүрдүүлэх асуудлаар байгууллагын ажилтнуудыг арга зүйгээр хангах зорилгоор сургалт зохион байгуулсан. Түр хадгалах хадгаламжийн нэгжийн гэмтэлтэй баримтыг сэлбэн засаж, сэргээсэн, нийт 1225 хадгаламжийн нэгжийг шинэчлэн бүртгэсэн. Архивын ерөнхий газарт Байнга хадгалах хадгаламжийн нэгжийг /2008-2018/ хүлээлгэн өгөхтэй холбоотойгоор 2008-2019 оны нийт 384 хадгаламжийн нэгжид шалгалт хийн дахин боловсруулалт хийсэн. 2008-2016 оны “Байнга хадгалах хадгаламжийн нэгж”-ийг цахим хэлбэрт шилжүүлж програмд оруулах бэлтгэл ажлыг хангаж, Архивын ерөнхий газарт хүлээлгэн өгөх цахим хувилбарыг бэлтгэж ажиллаа.

Байгууллагын архивт 2020 оны баримтаар нөхөн бүрдүүлэлт хийгдсэн. Нийт 345 хадгаламжийн нэгж бүрдүүлээд байна.

#### Хүснэгтээр харуулбал:

№	Хэлтэс	Он, цаг	Архивын нэр	Дүн тоо
1	Удирдлагын баримт	2020	Байнга хадгалах хадгаламжийн нэгж /Цахим хувилбартай/	55
		2020	70 жил хадгалах хадгаламжийн нэгж	15
		2020	Түр хадгалах хадгаламжийн нэгж	275
2	Төслийн баримт	2020	Байнга хадгалах хадгаламжийн нэгж	-
		2020	Ном	-
		2020	CD жагсаалт	-
НИЙТ				345

Хууль, эрх зүйн газар 2021 оны байдлаар иргэн, хуулийн этгээдтэй нийт 99 гэрээг дараах төрлөөр байгуулан ажиллаж байна. Үүнд:

№	Гэрээ		Нийт 99 гэрээ шинээр байгуулсан.
1	Ажил гүйцэтгэх гэрээ	17	
2	Үйлчилгээ үзүүлэх гэрээ	26	
3	Тээвэрлэлтийн гэрээ	13	
4	Түрээсийн гэрээ	9	
5	Худалдах худалдан авах гэрээ	16	
6	Хамтран ажиллах гэрээ	1	
7	Газар эзэмших гэрээ	3	
8	Зээлийн гэрээ	2	
9	Бусад	12	
10	Санамж бичиг	0	
	Нийт	99	

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан Ажил гүйцэтгэх гэрээг CD-д хуулбарлан Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

#### **Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**

Авлигатай тэмцэх газраас 2021 оны 4 дүгээр сард зохион байгуулсан Авлигын эсрэг цахим сургалтад тус компанийн эрх бүхий шинээр томилсон албан тушаалтныг оролцуулсан.

Компанийн зохион байгуулалтын бүтцэд нийцүүлэн Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргах эрх бүхий албан тушаалтны 2021 оны жагсаалтыг шинэчлэн Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан.

"Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын ашиг сонирхлын мэдүүлгийн хянасан дүгнэлт Авлигатай тэмцэх газраас ирүүлснийг харьяалах Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлсэн.

Мөн "Монголиан порт групп" ХХК-ийн шинээр томилсон Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт хариуцсан эрх бүхий албан тушаалтны судалгаа, мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр хүргүүлсэн.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд 2021 оны 02 сарын 15-ны байдлаар Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/, зохих тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, тайлагнасан.

Тайлант онд шинээр нэмэгдсэн болон хасагдсан албан тушаалтны мэдээллийг салбарын эрх бүхий албан тушаалтанд цахимаар илгээсэн.

2021 оны байдлаар Авлигатай тэмцэх газраас дүгнэлт гаргуулсан 22 албан тушаалтан байгаа ба үүнээс шинээр томилогдсон 5, шинэчлэн гаргасан 17 албан тушаалтан ХАСХОМ гаргаад



байна. Үүнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн-4, “Монпорт групп” ХХК-ийн 4 эрх бүхий албан тушаалтан багтсан.

Мэдүүлгээ хугацаа хоцроож мэдүүлсэн, гаргасан албан тушаалтан байхгүй.

### **Гэрээ, эрх зүйн нийтлэг асуудлаар**

Гадаадын зээл эд хөрөнгийн үр ашигтай, оновчтой ашиглах, эзэлийн эргэн төлөлтийг хангах зорилгоор МТЗ-ын машин механизмыг үнэ, төлбөртэйгээр ашиглуулах гэрээг байгуулах асуудлыг түргэвчлэхэд дэмжлэг үзүүлэх тухай албан бичгийг Зам, тээврийн хөгжлийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус хүргүүлсэн ба ТӨБЗГ-аас татгалзах зүйлгүй, ЗТХЯ-аас дэмжиж УБТЗ ХНН-т уламжилсан тухай хариу ирүүлээд байна.

Машин механизм, ажиллах хүчийг төлбөртэйгээр (түрээс) ашиглуулах асуудлаар материал бэлтгэж Дэд ажлын хэсгийн хуралдаанаар танилцуулсан. Уг ажлын хэсэг нэгж үнэ, нийт үнэ, ажлын гүйцэтгэл, төлбөр тооцооны асуудлыг тодруулж дахин оруулахаар хойшлуулсан. Энэхүү гэрээг Зэвсэгт хүчний Барилга инженерийн цэргийн удирдах газартай байгуулахаар тогтож, гэрээний төслийг хүргүүлсэн.

“Монголын төмөр зам” ТӨХК нь 2019-2020 онд нийт 298 гэрээ байгуулснаас Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлтэй холбоотой 211 гэрээ дуусгавар болж, гэрээг дүгнэх ажил хийгдэж байна.

### **Компанид холбогдох гомдол, маргааны хүрээнд:**

Тайлант хугацаанд компанийн хэмжээнд гэрээний хэрэгжилттэй холбоотой 2 маргаан шүүхийн шатанд хянагдаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд 4 иргэний хэрэгт ажиллагаа хийгдэж байна.

“Транскон” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Монголын төмөр зам” ТӨХК-нд холбогдох, “Экогидро гео” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Монголын төмөр зам” ТӨХК-нд иргэний хэргүүд Улсын дээд шүүхээр хянагдаж Анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан болно.

Хэргүүд анхан шатны шүүхэд ажиллагаа хийгдэж байгаа ба бодит хохирлыг тогтоолгохоор шүүгчийн захирамжаар шинжээч томилсон байна.

Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт “Энжелик” ХХК /318.900.0 төг/, “Эм Вай Си” ХХК /280.500.0 төг/, “Жи Ди Ай Эм” ХХК /43.510.0 төг/, “Засаг чандмань майнз” ХХК-уудад /8000 ам.доллар/ холбогдох иргэний хэрэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байна.

“Баз автоматив” ХХК-иас 1 774 000 төгрөгийн авлагатай байсан ба 2021 оны 05 дугаар сард барагдуулсан болно.

### **Худалдан авах:**

#### **Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд:**

2021 оны байдлаар компанийн хэмжээнд 8 ширхэг нээлттэй тендер зарласан ба 1 тендерийг Засгийн газрын 34-р тогтоолын дагуу хүчингүй болгосон, 1 тендерт шаардлага хангасан оролцогч байхгүй тул цуцалсан, 1 тендерийн урилга зарлагдаад хуулийн хугацаандаа явагдаж байна. Тендер шалгаруулалтыг амжилттай зохион байгуулан, шалгарсан оролцогч нартай хуулийн дагуу гэрээ байгуулан хамтран санал гомдолгүйгээр ажилласан. Төв оффисын болон Төмөртэй өртөөний үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө оруулалт, сэлбэг эд анги, бараа материал, хамгамжийн зүйлсүүдийг шууд худалдан авалтаар болон харьцуулалтын аргаар худалдан авалт хийгдсэн.

Худалдан авах үйл ажиллагааны холбогдох мэдээ мэдээллийг тухай бүр нь Сангийн яамны нэгдсэн шилэн данс /www.shilendans.gov.mn/ болон компанийн цахим хуудсанд /www.mtz.mn/, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайтуудад тус бүр байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган олон нийтэд мэдээлэн ажилласан.

## **Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт:**

Шилэн дансны тухай хууль тогтоомж, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу компанийн шилэн данс, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын мэдээллийн нэгдсэн сан буюу Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нэгдсэнтэй холбогдуулан шаардлагатай бүх мэдээллийг байршуулж, компанийн админ хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, компанийн цахим хуудсанд байршуулж нээлттэй ажиллаж байна. Тодруулбал, Сангийн яамны нэгдсэн шилэн дансанд Сангийн яамны нэгдсэн админаас ирүүлсэн чиглэлийн дагуу мэдээллийг тогтмол цаг тухай бүрт нь оруулан мэдээллэж байна.

Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоолоор баталсан журамд заасан бусад мэдээллийг компанийн цахим хуудсанд байршуулснаар олон нийт компанийн үйл ажиллагааны талаар хамгийн бодитой үнэн зөв мэдээллийг олж авах боломж бүрдсэн.

## **Хууль тогтоомжийн хүрээнд эрх зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, хууль зүйн дүгнэлт гаргах, компанийн ашиг сонирхлыг зохих байгууллагад төлөөлөх:**

Гүйцэтгэх захирлын 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/47 дугаар тушаалаар батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны журмын 13, 15 дугаар зүйл буюу “Гэрээ, акт, эдгээртэй адилтгах бусад баримт бичиг зохион бүрдүүлэх”, “Албан бичиг хөтлөх журам” сэдвүүдээр компанийн нийт ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн талаарх сургалт Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуу кемпүүдэд байрлаж буй нийт ажилтан, албан хаагчдад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжилтийг хангаж ажиллах талаар сургалтыг 2021 оны 3 дугаар сарын 20-26-ны өдрийг дуустал албан томилолтоор ажиллаж, зохион байгуулсан.

Мөн компанийн нийт ажилтан, албан хаагчдад Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн дотоод журмын талаар цахим сургалт зохион байгуулсан.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2020 оны 16/05 дугаар хуралдааны тэмдэглэлд заасны дагуу төмөр замын дэд бүтэц барих зориулалт бүхий орчин үеийн машин механизм бүхий төрийн өмчит аж ахуйн нэгж байгуулах хууль эрх зүйн үндэслэлийн талаар мэргэжил, арга зөвлөгөө, Сайдны зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулга бэлтгэж, тус компанийн Ажлын хэсэгт хүргүүлсэн.

Төмөр замын барилга, зам засвар арчлалтын чиглэлээр зам анги байгуулах асуудалд ТӨБЗГ болон ЗТХЯ-наас чиглэл өгч, Төлөөлөн удирдах зөвлөлд хэлэлцүүлэн Замын анги байгуулах шийдвэр гаргуулсан.

Хяналт шинжилгээ

## **Хууль тогтоомж, харьяа дээд байгууллага, удирдлагын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох тайлан мэдээ бэлтгэх:**

Гүйцэтгэх захирлын 2018 оны А/04 дугаар "Харьяа яам, агентлагт тогтмол гаргаж хүргүүлэх мэдээ тайлангийн хуваарь батлах тухай" тушаалын хүрээнд Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон Зам, тээврийн хөгжлийн Сайд, ТНБД-ын тушаалын биелэлтийн тайланг улирал, хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж ЗТХЯ-ны ХШҮДАГ-т хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. 2019 оны жилийн эцсийн тайланг 2019 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар гаргаж хүргүүлсэн. 2019 оны 3 дугаар улирлын байдлаар Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт 94.1 хувьтай, ЗТХС-ын тушаалын биелэлт 91.74 хувьтай, ЗТХЯ-ны ТНБД-ын тушаалын биелэлт 100 хувьтайгаар үнэлэгдсэн.

## **Эрх зүйн үр дагавар бүхий баримт бичгийн эх боловсруулах, хууль зүйн үндэслэлийг хянах:**

2021 оны байдлаар Гүйцэтгэх захирлын тушаалын А-45, Б-107 нийт 152 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, газрын ажилтнууд тайлант хугацаанд 41 албан бичгийн төсөл боловсруулж, газарт цохогдсон 224 албан бичгийг судлан шийдвэрлэсэн байна.

## **Хууль тогтоомж, бусад эрх зүйн актын төсөлд санал өгөх:**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 270 дугаар тогтоолоор “МТЗ” ТӨХК нь Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дахь заалтыг зөрчиж ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй” гэсэн зөрчил илэрсэн байна. Уг тогтоолын дагуу “МТЗ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар “Монголын төмөр зам” ТӨХК-ийн ногдол ашгийн журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, уг ажлын хэсэг “МТЗ” ТӨХК-ийн ногдол ашгийн журмын төсөл боловсруулсан. Журмын төсөлд компанийн газрын дарга нараас нэг бүрчлэн санал авч, саналуудыг журмын төсөлд тусгасан. Одоогийн байдлаар “МТЗ” ТӨХК-ийн ТУЗ-д танилцуулах үе шаттай явж байна.

### 3.5 Гадаад харилцаа

Компанийн гадаад хамтын ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэхдээ Монгол улсын гадаад харилцаанд баримтлах бодлого, төрийн захиргааны төв байгууллагын удирдлагын тушаал шийдвэр, эрх зүйн баримт бичигт нийцүүлэх чиглэл баримтлан ажиллаж байна. Тайлант хугацаанд Ковид-19 цар тахалын нөхцөл байдлаас үүдэн гадаад томилолт, хурал, уулзалт биечлэн хийгдэх боломжгүй байгаа бөгөөд бүхий л үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн гадаадын харилцагч байгууллагуудтай өдөр тутам албан бичиг, захидал болон цахим харилцаагаар харилцаж, шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг орчуулж, холбогдох газар, нэгжүүдтэй хамтран ажиллаж байна.

**Гадаад харилцаа хамтын ажиллагаанд баримтлах бодлогын хүрээнд:** Компанийн гадаад хамтын ажиллагаанд баримтлах бодлогыг бүхий л үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

**“Шинэ төмөр зам” төслийн хүрээнд:** Тайлант хугацаанд нийт 3 худалдан авах гэрээ, 3 бэлэглэлийн гэрээ, 1 санхүүжилтийн гэрээ, 1 нууцын гэрээ, 2 Санамж бичиг тус тус орчуулж боловсруулан, гарын үсэг зурах ажиллагааг зохион байгуулсан. Бэлэглэлийн гэрээний дагуу төмөр замын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн бөгөөд хүлээлцэх, дагалдах гарын авлага орчуулж боловсруулах, тээвэрлэлтийг зохион байгуулах ажлыг холбогдох газрын хамт хэрэгжүүлсэн. Төслийн ажилд шаардлагатай олон улсын техникийн болон бусад судалгааны ажлуудыг орчуулж танилцуулах, үнийн судалгаа хийх зэргээр бусад газруудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилласан.

#### **Төлөвлөгөөт ажлын хүрээнд:**

Хятад-Англи-Монгол хэл дээр төмөр замын үг хэллэг бүхий нийт 1500 орчим хуудастай толь бичиг орчуулах ажлыг хэрэгжүүлж эхлээд байна.

**Тяньжин төслийн хүрээнд:** Тус төслийн хүрээнд төслийн хөрөнгө оруулалтын асуудал хүлээгдэж байгаа тул холбогдох ажлууд хойшлогдсоор байна.

#### **Төмөр Замын Хамтын Ажиллагааны Байгууллага, Олон Улсын Төмөр Замын Холбооны хүрээнд:**

ТЗХАБ болон ОУТЗХ-ны зүгээс зохион байгуулагдаж буй сургалт, арга хэмжээний талаар тухай бүр мэдээлэл, урилга хүлээн авч орчуулж, мэдээллийг хүргэн ажилласан.

**Гадаад сурталчилгаа, бусад ажлын хүрээнд:** Тавантолгой-Зүүнбаян төмөр замын төслийн хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга болон ЖАЙКА Олон улсын байгууллагад танилцуулах төслийн танилцуулгыг тус тус орчуулж, боловсруулсан. Компанийн тендер шалгаруулалтын хүрээнд орчуулах шаардлагатай албан бичиг, баримт бичиг орчуулах ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн.

#### **Гадаад томилолт:**

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан тайлант хугацаанд гадаад томилолт зохион байгуулагдаагүй.

### 3.6 Олон нийтийн харилцаа, маркетинг

**Компанийн үйл ажиллагаа, төслийн болон цаг үеийн шуурхай мэдээ, мэдээллүүдийг тогтмол бэлтгэх, цахим хуудас, цахим сүлжээнд мэдээллийг бэлтгэх, хөтлөх, тогтмол хөгжүүлэх ажлын хүрээнд:**

Тавантолгой-Зүүнбаян төслийн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг тогтмол шуурхай хүргэх, компанийн үндсэн үйл ажиллагааг сурталчилах зорилтын хүрээнд [www.mtz.mn](http://www.mtz.mn) цахим хуудас,

Mongolian railway фэйсбүүк, пэйж хуудсыг ажиллуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй тогтмол хамтран ажиллаж байна.

**Тайлант хугацаанд компанийн www.mtz цахим хуудсанд:** Цаг үеийн мэдээ мэдээлэл, нийтлэл сурвалжлага-23, ажлын байрны зар-16 бэлтгэн нийтэлсэн. Мэдээллийн ил тод байдлын хуулийн зүйл заалтуудын дагуу Авлигын эсрэг үйл ажиллагаа, Төсөв гүйцэтгэл, Хөрөнгө оруулалт, Худалдан авалт гэсэн 4 бүлэг 22 төрлийн мэдээллийг холбогдох хэлтсүүдээс нэгтгэн авч улирал бүрээр шинэчлэн оруулсан. Хүний нөөцийн буланд Компанийн үйл ажиллагаанд мөрдөх шинэчлэгдсэн дүрэм журам, хүний нөөцийн бүтэц бүрэлдэхүүний мэдээллийг нийтэлж байна. Мөн компанийн үндсэн үйл ажиллагааны танилцуулга, Тяньжин, Замын-Үүд тээвэр логистикийн төв, Төмөртэй өртөө, Шинэ төмөр зам төслийн мэдээллийг шинэчлэн боловсруулж, англи-монгол хэлээр оруулсан.

**Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй тогтмол хамтран ажиллах, мэдээллийн хэрэгслүүдээр компанийн цаг үеийн чанартай мэдээ мэдээллийг олон нийтэд түгээх:**

Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах хүрээнд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талбайд албан томилолтоор ажиллаж, Дээд бүтцийн үе угсралт, Аж ахуйн галт тэрэг аялуулах туршилт, МСҮТ төгсөлт, Хопер вагоноор балласт тээвэрлэх туршилтын үйл явдлын 4 удаагийн сурвалжлага бэлтгэн түгээсэн.

Телевизийн сувгуудаар: Нийт 6 удаагийн мэдээ /MNB, Eagle, 25-р суваг, ETV,SBN,TV-5/ дамжуулав.Үүнд:

- “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талбай дээрээс Дээд бүтцийн үе угсарч дууслаа”
- “Аж ахуйн галт тэргийг амжилттай аялууллаа”
- “МСҮТ төгсөлтийн гэрчилгээ гардуулав”
- “Хопер вагоноор балласт тээвэрлэх туршилтын үйл ажиллагаа зохион байгууллаа”
- “Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын ТТ-ЗБ төслийн үйл ажиллагаатай танилцав”
- “Төмөр замын бүтээн байгуулалтад гаргасан гавьяаг үнэлж Төрийн дээд одон медалиар шагналаа”

Сайтад-21 удаагийн мэдээ, сурвалжлага /Itoim.mn, 24tsag.mn, Postmedia.mn, UBnews.mn, Montsame.mn/

Өдөр тутмын сонин-5 удаагийн ярилцлага, 2 удаагийн мэндчилгээ / Өдрийн сонин, Өнөөдөр, Зууны мэдээ, Монголын мэдээ, Ган зам/ бэлтгэн тус, тус бэлтгэн нийтэлсэн.

- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ-2
- Р.Батсүх: Төмөр замаар дэлхийн тээвэр худалдааны гинжин хэлхээнд холбогдлоо
- Р.Батсүх: Төмөр зам, уул уурхай бол нэг зоосны 2 тал
- Д.Нямлхагва: Тавантолгой-Зүүнбаянгийн төмөр замаар хоёрдугаар улиралд багтаан туршилтын галт тэрэг аялуулахаар төлөвлөж байна
- Ж.Энхбаяр: Тавантолгой-Зүүнбаян төмөр замын стандарт, техникийн шаардлага нь нэгдүгээр зэрэглэлийнх
- Б.Энэрэлт: Хямд өртгөөр төмөр зам барьсан анхны амжилттай түүхийг Тавантолгой-Зүүнбаян чиглэлд бүтээлээ

**Олон нийтийн сүлжээ:**

“Монголын төмөр зам” ТӨХК фэйсбүүк пэйж хуудас болон facebook account-ыг тогтмол хөтөлж байна. Тайлант хугацаанд 54 пост /зурагт мэдээлэл, мэдээ, ярилцлага, шэйр гм/ оруулсан. Дагагчийн тоог 10.000 хүргэсэн.. Мөн twitter хуудсаар 12 удаагийн мэдээ мэдээлэл нийтэлсэн.

**Маркетинг, сурталчилгааны ажлын хүрээнд:**

**/Танилцуулга, видео шторк/**

- “Дорно-Өрнийг холбох Монголын төмөр зам” Тавантолгой-Зүүнбаян төмөр зам төслийн бүтээн байгуулалтын ажлыг түүхчилсэн 40 минутын баримтат киног бүтээлгэсэн.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн видео танилцуулга
- Монголын төмөр зам ТӨХК-ийн үндсэн үйл ажиллагааны танилцуулга /англи, монгол хэл дээр/
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн гүүр хоолой, дам нурууны ажлын танилцуулгыг тус, тус бэлтгэн сошиал сувгуудаар түгээж, үйл ажиллагаанд тогтмол ашиглаж байна.

**Бэлэг дурсгал:**

Компанийн лого бүхий энгэрийн тэмдэг, цаасан тор тус тус хийлгэсэн. Компаниудаас үнийн санал авч харьцуулсан судалгаа хийсэн бөгөөд удирдлагуудаас санал авч гэрээ байгуулсан.

#### **Ном, товхимол:**

МҮХАҮТ-ийн 60 жилийн ойн хүрээнд компанийн танилцуулга материал, анонс бүхий 100 ш товхимол бүтээлгэн албан хэрэгцээнд ашиглаж байна.

### **3.7 Мэдээлэл технологи**

#### **“Докс” и-оффис систем:**

Байгууллагын дотоод хэрэгцээнд зориулж вебд суурилсан “Докс” и-оффис системийг хөгжүүлж байна. Энэхүү систем нь хүний нөөц, цаг бүртгэл, албан бичиг, тушаал, архив, хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл, шуурхай хурал, төлөвлөгөө биелэлт, гэрээ бүртгэл гэсэн дэд програмуудтай судалгаа, санал асуулга, хэрэгцээт файлууд, зургийн цомог гэсэн дэд модулиудтай ба бүх ажилчид холбогдох боломжтойгоороо давуу талтай юм. Албан бичиг, тушаал, ажлын даалгавар ирэх зэргийг мэдээлэх, хариутай албан бичиг, өргөдөл гомдол, гэрээт ажилчдын гэрээ дуусах хугацаа, зэргийг сануулах функцээр өдөр тутмын ажлыг шуурхай хэрэгжүүлж ажиллаж байна. Хайлт шүүлтийн функцийг бүх дэд программуудад хийж өгсөн ба мэдээллийг оновчтойгоор хайх, шүүх боломжтой.

Албан бичгийн программ нь ирсэн явсан бичиг, тушаал бүртгэх ба хайж шүүхэд хялбар, холбогдох ажилтанд цахимаар шилжүүлдэг тул цаас хэмнэлтэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг.

Архивын программ нь “Архивын ерөнхий газар”-ын программтай холбогдож ажиллах бүрэн боломжтойгоор хийгдсэн бөгөөд цахимаар архивын материал хүлээлгэн өгөхөд өгөгдлийн баазыг шууд хуулж болно.

Хүний нөөцийн программ нь Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн ба мэдээллийг олон төрлөөр бүртгэх боломжтой бөгөөд ажилчид өөрсдийн хөдөлмөрийн харилцааны мэдээлэл болон ирц бүртгэл, ажилласан жил, цаг ашиглалт, олон төрлийн тайланг нэгдсэн форматаар гаргах, төлөвлөх, санал асуулгад оролцох зэрэг шаардлагатай мэдээллийг авах, хянах боломжтой. Мөн графикчилсан мэдээллүүд дээр үндэслэж хүний нөөц бүрдүүлэлтэд дүн шинжилгээ хийх бололцоотой.

Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэлийн программд зүтгүүр болон вагоны ерөнхий мэдээлэл, засвар үйлчилгээтэй холбоотой мэдээллүүдийг бүртгэж байна.

Төлөвлөгөө биелэлтийн программыг хэрэглээнд нэвтрүүлж эхэлж байгаа ба энэхүү программаар ажилчид 7 хоногийн төлөвлөгөө, биелэлтээ бичиж, хэлтсүүд болон хэлтсийн чиг үүргээр автоматаар бүлэг үүсч, нэгдсэн тайлан гаргадаг.

Гэрээ бүртгэлийн программ нь гэрээнд оролцогч, хариуцагч нарыг бүртгэж эхлэх дуусах хугацаанд суурилж гэрээг сунгах, цуцлах тухай мэдээлэл өгдөг. Мөн гэрээний явцын дүгнэлт бичих боломжтой. Цаашид гэрээг цахимаар хэлэлцүүлж боловсруулахаар ажиллаж байна.

Норматив үзлэгийн программ нь инженерүүдэд хуваарьлагдсан нормативт ажлуудыг хугацааны давтамжаар сануулах, үзлэгийн биелэлтийг файлаар хавсаргаж тайлагнах үндсэн зорилготой. Энэхүү программын тусламжтайгаар хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтэц, барилга байгууламжтай холбоотой нормативт үзлэгүүдийг хариуцсан инженерүүд цаг тухай бүрт хийж гарч болох эрсдлүүдээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

Тээврийн программ нь Төмөртэй өртөөний ачилтын мэдээллийг нэгтгэж тайлагнах зорилготой. Воганаар тээвэрлэж буй экспортын болон дотоодын ачаа тээврийн мэдээлэл, автомашинаар гаалийн талбайд бууж буй ачааны мэдээлэл дээр үндэслэн захиалгат тээвэр төлөвлөсөн хугацаанд дуусах эсвэл хоцрох зэргийг тооцож анхааруулдаг. Энэ нь ажлын гүйцэтгэлийг хянаж менежмент хийх бололцоогоор хангах давуу талтай юм.

#### **Төслийн удирдлагын “Прайм прожектс” программ:**

Төслийн удирдлагын “Прайм прожектс” программыг хөгжүүлж эхний хувилбарыг хэрэглээнд нэвтрүүлсэн. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416,1 км төмөр замын төслийн газар шороо, гүүр, хоолой, дээд бүтэц угсралт, материал үйлдвэрлэлт, эрчим хүч, барилга, дохиолол холбооны ажлуудын төлөвлөгөө гүйцэтгэлийг уг программаар хянан ажиллаж байна.

Мэдээллийн нууцлалын зэргээс хамаарч хэрэглэгчид өөрийн эрхийн хүрээнд мэдээлэлд хандах ба холбогдсон хэрэглэгч нарын үйлдлүүдийг хадгалдаг.

Зам, тээврийн хөгжлийн яамны хэрэгжүүлж буй авто замын төслүүдийг нэгтгэн хянах програмчлалыг хийсэн ба тус яамны серверт программ хангамжийг суурилуулж хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

#### 4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Монголын төмөр зам” ТӨХК нь 2021 оны хагас жилийн гүйцэтгэлээр тээвэрлэлтийн болон түрээсийн үйл ажиллагаанаас 8.8 тэрбум, хүү болон бусад үйл ажиллагаанаас 0.2 тэрбум **нийт 9.1 тэрбум төгрөгийн** орлоготой ажилласан байна. Нийт зардал хагас жилийн гүйцэтгэлээр **9.5 тэрбум** төгрөг гарсан ба үндсэн үйл ажиллагаанаас **0.4 тэрбум** төгрөгийн алдагдалтай ажилласан нь цар тахлын бүх нийтийн хөл хориотой холбоотой. Ханшийн зөрүүний бодит бус алдагдал 0.2 тэрбум болж татварын өмнөх алдагдал 0.6 тэрбум төгрөг болсон байна.


№	ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	2019 оны II улирал	2020 оны II улирал	2021 оны II улирал	Зөрүү
1	<b>ОРЛОГО</b>	мян.т	6,104,841	<b>10,646,146</b>	<b>9,066,341</b>	<b>-1,579,805</b>
1.1	Үндсэн үйл ажиллагааны орлого	мян.т	4,869,421	8,025,723	8,849,175	823,452
1.2	Хүүгийн орлого болон бусад ашиг	мян.т	1,235,420	2,620,423	217,166	-2,403,257
2	<b>ЗАРДАЛ</b>	мян.т	<b>4,425,593</b>	<b>6,484,231</b>	<b>9,463,446</b>	<b>2,979,215</b>
2.1	Борлуулалтын өртөг	мян.т	1,691,266	1,931,446	7,847,338	5,915,892
2.2	Ерөнхий ба удирдлагын зардал	мян.т	2,734,327	4,552,785	1,616,108	-2,936,677
3	<b>АШИГ (АЛДАГДАЛ)</b>	мян.т	<b>1,679,247</b>	<b>4,161,925</b>	<b>-397,105</b>	<b>-4,559,030</b>
4	<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ (АЛДАГДАЛ)</b>	мян.т	<b>-618,965</b>	<b>-3,450,751</b>	<b>-191,699</b>	<b>3,259,052</b>
5	<b>ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)</b>	мян.т	<b>1,060,282</b>	<b>711,164</b>	<b>-588,804</b>	<b>-1,299,978</b>
6	<b>ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР</b>	мян.т	<b>112,161</b>	<b>258,517</b>		<b>-258,517</b>
7	<b>ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)</b>	мян.т	<b>948,121</b>	<b>452,647</b>	<b>-588,804</b>	<b>-1,041,451</b>

#### Орлогын үзүүлэлт.

“Монголын Төмөр Зам” ТӨХК нь 2021 оны хагас жилийн гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 9.1 тэрбум төгрөг буюу гүйцэтгэл 103%-тай байна.

Замын-Үүдийн шилжүүлэн ачих байгууламжийн түрээсийн орлого 327.3 сая төгрөг, вагон түрээс 3.0 тэрбум төгрөг, зүтгүүр түрээс 471.8 сая төгрөг, Төмөртэй өртөөний тээвэрлэлтийн үйл ажиллагааны орлого 2,5 тэрбум, логикийн түрээс 1.6 тэрбум төгрөг, зам засварын машин тоног төхөөрөмжийн түрээс 997.4 сая төгрөг, бусад орлого (хүүгийн орлого) 113.2 сая төгрөг тус тус эзэлж байна.

## Орлого




- Төмөртэйн тээвэр
- Вагон түрээс
- Логистик
- Машин механизм түрээс
- Зүтгүүр
- ШАЦ түрээс
- Бусад

## Зардлын үзүүлэлт

“Монголын Төмөр Зам” ТӨХК нь 2021 оны хагас жилийн гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны зардал 9.5 тэрбум төгрөг буюу 83%-тай байна. Томоохон зардлууд нь цалингийн зардал 1.1 тэрбум төгрөг 12%, элэгдлийн зардал 4.8 тэрбум төгрөг 51%, зээлийн хүүгийн зардал 2.5 тэрбум төгрөг 26%, бусад зардал 1.1 тэрбум төгрөг 11%-ийг тус тус эзэлж байна


## Зардал



- Цалин
- Элэгдэл
- Зээлийн хүү
- Бусад

## Төлөвлөгөө биелэлт

Компани 2021 онд батлагдсан зорилтот түвшний биелэлтийг хангах, үргүй зардлыг бууруулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласны үр дүнд төлөвлөгөөт зардлын хэтрэлтгүй 1.9 тэрбум төгрөгөөр хэмнэж, орлогыг 0,3 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлж ажилласан байна.



### 2021 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

“Монголын Төмөр Зам” ТӨХК нь 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, ТӨБЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 682 дугаар тогтоолоор батлуулсан.

Компани 2021 онд хөдлөх бүрэлдэхүүн түрээсийн болон тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас 22.9 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 22.8 тэрбум төгрөгийн зардал гарган нийт 157.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн. 2021 онд цар тахлын нөхцөл байдлын улмаас 397.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

### Төлөвлөгөөт хугацаанд дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөв. Үүнд:

- 245 ачааны вагоныг төлөвлөгөөт дунд засварт оруулах, тээвэрлэлтэд бэлтгэх;
- БНХАУ-ын “Си Ар Ар Си” компанийн нийлүүлсэн 28.6 сая ам долларын зам засварын машин механизмын хөрөнгүүдийн дамжуулан зээлийн гэрээг хийж, эргэн төлөлтийн хувиарыг тохирч, байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэж аван, хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлж ажиллах
- Бүс нутгийн логиستيкийн төвийн хөрөнгийн зээлийн гэрээг байгуулж, эргэн төлөлтийн хувиарыг батлуулж өөрийн хөрөнгөд бүрэн хүлээн авч бүртгэх
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дуусгах
- БНХАУ-ын “Тяньжин порт групп” компанитай хамтарсан компани байгуулж Тяньжин төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх;
- Өөрийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг ашиглан 100 ширхэг хагас вагон худалдан авах мөн Төмөртэй өртөөнд автопүү шинээр барьж ашиглах зэргээр үйл ажиллагааны орлогоо нэмэгдүүлж ажиллана.



## 5.ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

### 5.1 Инженер, технологийн чиглэлийн үйл ажиллагаа

#### 5.1.1 Хөдлөх бүрэлдэхүүний парк:

ЗҮТГҮҮР		
№	Төрөл	Тоо хэмжээ, ш
1	СКD4В серийн гол замын зүтгүүр	5
2	EVO ES44ACi серийн зүтгүүр	1
3	2ТЭ-116 серийн зүтгүүр	2
4	DF7G серийн сэлгээний зүтгүүр	1
НИЙТ		9

ВАГОН		
№	Төрөл	Тоо хэмжээ, ш
1	EC70A загварын ачааны хагас вагон	185
2	EN70 загварын ачааны тавцант вагон	50
3	EP70 загварын ачааны битүү вагон	10
НИЙТ		245

Зам засварын машин механизм		
№	Төрөл	Тоо хэмжээ, ш
1	DC-32W загварын балласт чигжигч, чиг татагч машин	2
2	WD-400W загварын балласт тогтворжуулагч машин	2
3	SPZ-200W загварын балласт тохируулагч машин	2
4	QS-650W загварын балласт цэвэрлэгч машин	1
5	GC-220K загварын мотовоз	1
6	KZ75-1520 загварын хоппер вагон	57
НИЙТ		65

Техник, тоног төхөөрөмж		
№	Төрөл	Тоо хэмжээ, ш
1	Хүнд даацын чингэлэг тээвэрлэгч машин /Калмар/	2
Газар шорооны машин механизм, тоног төхөөрөмж		
1	ISUZU CX81K Самосвал	2
2	TADANO TL250E Автокран	2
3	КОМАТСU D65E Бульдозер	2
4	CAT 322C Эксковатор	2
5	KND1100 Бетон зуурагч	2
6	MDR 9D Доргиурт нягтруулагч индүү	1
7	№15-394 Хий хэмжигч, суулт хэмжигч, цилиндр хэв	2
НИЙТ		13

5.2 Хөдлөх бүрэлдэхүүний түрээсийн талаар судалгаа

	Вагоны төрөл	Түрээслэгч компани	Тээвэрлэж буй ачааны нэр	Нэгжийн тоо	Түрээсийн гэрээ дуусах	Тайлбар
	Ачааны вагон	Битүү	“БОМБ” ХХК	Цементээс бусад төрөл бүрийн ачаа	5	2021.04.12 /хугацаа сунгагдсан/
“Эй Ти Эм Ти” ХХК			Цементээс бусад төрөл бүрийн ачаа	5	2021.10.23	Ашиглалт хэвийн.
Тавцант		“Талын хишиг майнинг” ХХК	Контейнер, техник, тоног төхөөрөмж	50	2021.12.31	Ашиглалт хэвийн.
Хагас		“Талын хишиг майнинг” ХХК	Төмрийн хүдэр	145	2022.04.01	Ашиглалт хэвийн.
	40			2022.01.15	Ашиглалт хэвийн.	
Зүүгүүр	DF7G MR-2401	“МТЗ ТӨХК”-ийн харьяа Төмөртэй өртөөний тээвэрт	Төмрийн хүдэр	1	Төмөртэй өртөөний сэлгээний зориулалтаар ашиглаж байна.	DF7G MR-2401
	СКД4В MR 2303,2305	“МТЗ ТӨХК”-ийн харьяа Төмөртэй өртөөний тээвэрт	Төмрийн хүдэр	2	Төмөртэй-Хандгайт чиглэлд ачаа тээвэрт ашиглаж байна.	
	СКД4В 2302	ТТ-ЗБ чиглэлийн шинэ төмөр замын дээд бүтэц угсралтад ашиглаж байна.	Төмөр замын балласт	1	Төслийн талбайн 60-129 дүгээр км-т байрлан ашиглаж байна.	
	СКД4В 2304	ТТ-ГС чиглэлийн Төмөр замын дээд бүтэц угсралтад ашиглаж бна.	Төмөр замын балласт	1	“Бодь Интернэшнл” ХХК-д түрээсээр ашиглуулж байна.	
	СКД4В 2301	Замын-Үүд-Эрээн чиглэлд зөөврийн галт тэргэнд	Төрөл бүрийн ачаа	1	УБТЗ ХНН-н Замын Үүд Дөпөд түрээсээр ашиглуулж байна.	
	EVO ES44ACi MR-2101	Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутаг дахь Төмөртэй өртөөнд хүйтэнд зогсож байна.		1	Covid-19 цар тахлаас шалтгаалсан улсын хил хаасан нөхцөл байдалтай удаан хугацаанд үргэлжилж байгаа тул их засвар хийлгэх ажлыг зохион байгуулахад саад учирч удааширсан. Энэ оны 2 дугаар хагаст компанийн бизнес төлөвлөгөөний тодотголд суулган хилийн хорио /Covid-19/-оос шалтгаалсан нөхцөл байдал сайжирч хэвийн болвол их засвар хийлгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулна.	
	2ТЭ-116 2201, 2202	Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутаг дахь Төмөртэй өртөөнд хүйтэнд зогсож байна.		2	Их засварт орох шаардлагатай. Төмөртэй өртөөнд хүйтэн нөөцөд байрлуулсан.	

Техник	Калмар-2ш	Замын-Үүд дэх ШАБ-д ажиллаж байгаа	Чингэлэг ачигч	2	“УБТЗ” ХНН-ийн Замын-Үүд дэх МЧ-д түрээсээр ажиллаж байна.	
Газар шорооны машин шороо	Komatsu D65E бульдозер №521	Төмөртэй өртөөнд	Газар шорооны ажил	1		
	Komatsu D65E бульдозер №522	ТТ-ЗБ төслийн талбайд	Газар шорооны ажил	1		
	Isuzu самосвал 46-71УББ, 46-30УББ	ТТ-ЗБ төслийн талбайд	Газар шорооны ажил	2		
	Cat322C экскаватор №161	Төмөртэй өртөөнд	Газар шорооны ажил	1		
	Cat322C экскаватор №161	ТТ-ЗБ төслийн талбайд	Газар шорооны ажил	1		
	Автокран Tadano TL250E 3289УББ	ТТ-ЗБ төслийн талбайд	Кран угсрах, Төмөр замын хийц буулгах	1		

### 5.3 Хөдлөх бүрэлдэхүүний засвар, ашиглалт

#### 5.3.1 Зүтгүүрийн аж ахуйн чиглэлээр

“МТЗ ТӨХК”-ийн харьяа Сэлэнгэ аймгийн Хүдэр сум дахь Төмөртэй өртөөнд Төмөртэй-Хандгайт чиглэлийн зөөвөрт СКD4В серийн 2303, 2305 зүтгүүрийг, өртөөний сэлгээний хөдөлгөөнд DF7G-2401 зүтгүүрийг тус тус ашиглаж техникийн үзлэг, урсгал засварыг тогтмол хийн, техникийн хэвийн байдал, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

– СКD4В серийн 2302 зүтгүүрийг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн шинэ төмөр замын дээд бүтэц угсралтад сэлгээний ашиглаж байгаа бөгөөд шаардагдах зүтгүүрийн бригадуудыг хөлсөөр ажиллуулах гэрээгээр ажилуулан, техникийн үйлчилгээ, засварын ажлыг өөрсдийн засварын бригадаар хийж гүйцэтгэж, төслийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

– СКD4В 2301 зүтгүүрийг “УБТЗ” ХНН”-ийн Замын-Үүд-Эрээн хэсэглэлд зөөврийн галт тэргэнд ашиглах зориулалтаар түрээслүүлэн, гэрээнд заасны дагуу урсгал засваруудад шаардагдах сэлбэг материалаар ханган ажиллаж байна. Мөн техникийн байдалд гэрээт ажилтнаар дамжуулан тогтмол хяналт тавьж ажиллаж байна .

– Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, ТӨБЗГ-н 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 659 тоот тогтоолоор “МТЗ” ТӨХК-ийн 2020 онд бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд СКD4В серийн хоёр нэгж, Эволюшн (Evolution) серийн нэг нэгж зүтгүүрүүдэд дунд болон их засвар хийлгүүлэх төсөв суугдсан. Дээрх их болон дунд засвар хийх чадамж бүхий үйлдвэрлэгч гадны байгууллагуудтай (БНХАУ-н СИ АР АР СИ ДАЛЯНЬ , **CRRC Dalian Locomotive & Rolling Stock Co., Ltd.**) албан байдлаар харьцаж, урьдчилсан үнийн санал авахад нэгж зүтгүүрт дунд засвар хийх үнийн дүн төсөвлөгдсөнөөс өндөр байсан тул “МТЗ ТӨХК”-ийн ТУЗ-ийн 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн №10 тоот хурлын тогтоолоор тодотгол хийлгэн, EVO MR1001 зүтгүүрийн их засвар СКD4В зүтгүүрийн дунд засвар гэсэн төсөвт өртгийг тус бүр нэг нэгж болгон өөрчилсөн ба ТУЗ-ийн энэхүү шийдвэрийг 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн ТӨБЗГ-ын 468 тоот тогтоолоор зөвшөөрч баталсан. Гэвч Covid-19 цар тахлын улмаас удаа дараалсан дотоодын болон хөрш зэргэлдээ орнуудын хилийн хорионы улмаас уг их, дунд засварын ажлыг зохион байгуулах нөхцөл боломж бүрдсэнгүй. 2021 оны хагас жилийн тодотголд дээрх засварын ажлуудыг оруулахаар төлөвлөж байна.

– Зүтгүүрийн инженер техникийн ажилтнууд нь Төмөртэй өртөөний тээврийн тасралтгүй үйл ажиллагаанд зүтгүүрийн техникийн бэлэн байдлыг хангах, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн шинэ төмөр замын төслийн тасралтгүй үйл ажиллагаанд зүтгүүрийн техникийн бэлэн байдлыг хангах,

түрээсээр ашиглуулж буй зүтгүүрүүдийн техник ашиглалтад хяналт тавих зэрэг үндсэн үүргээ биелүүлэн компанийн хэмжээнд тээвэр болоод төслийн үйл ажиллагаанд өөрсдийн хувь нэмрийг оруулан ажиллаж байна.

– Үйл ажиллагаатай холбоотой “Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил гүйцэтгэх мэргэжилтэй ажилтан болон ажил гориллогчийг шалгаж, техникийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалт авах журам” боловсруулан Гүйцэтгэх захирлын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/27 тоот тушаалаар, Төмөртэй өртөөний тээвэрт СКD4В серийн зүтгүүрийн Төмөртэй-Хандгайт чиглэлд галт тэргэнд аялах үеийн түлшний зарцуулалтыг “Түлшний норм”-ыг боловсруулан Гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/04 тоот тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж эхэлсэн.

### 5.3.2 Вагоны аж ахуйн чиглэлээр

– Гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/12 тоот тушаалаар байгуулагдсан “Үндэсний хэмжээний төмөр замын дээд бүтцийн барилга угсралт ба засвар арчилгааны хуулийн этгээд байгуулах төсөл боловсруулах” Ажлын хэсэгт холбогдох мэргэжлийн чиглэлээр ажилласан.

– Гүйцэтгэх захирлын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/17 тоот тушаалаар байгуулагдсан “Англи-Хятад-Монгол хэл дээрх төмөр замын чиглэлийн үг хэллэг бүхий толь бичгийг орчуулах редакторлуулах” ажлын хэсэгт ажилласан.

– Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замд туршилтын галт тэргийг аялуулахтай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/31 тоот тушаалаар батлагдсан Ажлын хэсэгт мэргэжлийн чиглэлээр оролцон ажилласан.

– Төмөртэй өртөөний Техник үйлчилгээний газрын үйл ажиллагаанд мэргэжлийн чиглэлээр шаардлагатай зохион байгуулалтыг дор бүр нь хийж ажиллаж байна. Техник үйлчилгээний газар нь 2021 оны байдлаар нийтдээ 233 галт тэргийг хүлээн авч, 283 галт тэргийг явуулсан бөгөөд 12728 вагоныг ачилтад бэлтгэн галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

– Ачааны вагонуудыг зуны улиралд бэлтгэх үзлэг засварын ажилд бүрэн хамруулсан.

– “Ачааны вагоныг өвөл, зуны улиралд бэлтгэх үзлэг засварын ажлын журам”-ыг боловсруулж байна.

– 2021 оны 5 дугаар сараас 2021 оны 10 дугаар саруудад хуваарийн дагуу 245 ачааны вагон төлөвлөгөөт дунд засварт орохоос 68 ачааны вагоныг төлөвлөгөөт дунд засварт хамруулаад байна.

– “Төмөртэй өртөөний техник үйлчилгээний газарт эзэмшлийн бус ачааны вагонд хийх засварын ажлын үнэлгээ”-ний дагуу 2021 оны байдлаар нийтдээ 10 гаруй төрлийн 251 засвар үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 8,4 сая төгрөгийн орлогыг компанид оруулаад байна.

– “Төмөртэй өртөөний техник үйлчилгээний газарт эзэмшлийн бус ачааны вагонд хийх засварын ажлын үнэлгээ”-г шинэчлэн боловсруулж байна.

– “Төмөртэй өртөөний техник үйлчилгээний газрын технологийн процессыг шинэчлэн боловсруулсан. Хянагдаж байна.

– ГТХЗНТ-д “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ын дагуу тухай бүр Вагоны парк ашиглалтын тайланг /Маягт №9/ тогтмол гарган өгч байна.

### 5.3.3 Зам засварын машин механизмын чиглэлээр

– “Бодь Интернэшнл” ХХК-д түрээслэгдэж буй зам засварын СКD4В заварын 2304 дугаар бүхий 1 зүтгүүр, зам засварын 4 машин механизм болон 20 хоппер вагонууд нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын дээд бүтэц угсралтад ашиглагдаж байгаа бөгөөд ашиглалт, засвар үйлчилгээ, техникийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж ажиллаж байна. Ашиглалт хэвийн.

– Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дээд бүтэц угсралтад СКD4В заварын 2302 дугаар бүхий 1 зүтгүүр, зам засварын 3 машин механизм болон 37 хоппер вагонууд ашиглагдаж байгаа бөгөөд ашиглалт хэвийн байна.

– Газар шорооны Komatsu D65E маркийн №522 дугаартай бульдозер болон Cat322C маркийн №161 дугаартай экскаватор нь Төмөртэй өртөөнд ашиглагдаж байна.

– Компанийн эзэмшлийн автомашинуудын техник үйлчилгээ болон засвар үйлчилгээг тухай бүрт хийлгэн, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

## 5.4 Суурь бүтцийн чиглэлээр үйл ажиллагаа

#### 5.4.1 Замын чиглэлээр

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замын төслийн Тавантолгой өртөөний ажлын зураг төслийг боловсруулж дууссан ба магадлалын ерөнхий дүгнэлт хийлгэсэн.
- “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замын засварын депогийн зураг төслийг бүрэн боловсруулж дууссан.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын хориг хашааны ажлын зураг төсөл болон төсвийг боловсруулж, ерөнхий гүйцэтгэгч “УБТЗ” ХНН-т хүргүүлсэн.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг элсний нүүдлээс хамгаалах богино болон урт хугацааны төлөвлөгөөг боловсруулж, төсөвт өртгийн тооцоог гаргасан.
- Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн дээд бүтцийн угсралтын ажлыг удирдлагаар хангаж, захиалагчийн хяналт тавьж ажилласан ба гол замыг холбож дууссан. Нийт дээд бүтцийн угсралтын гүйцэтгэл 75 хувьтай байна.
- “Богд хан” төмөр замын бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулж ЗТХЯ-нд танилцуулсан. Газар дээр нь ЗТХЯ-аас байгуулсан Ажлыг хэсэгт ажилласан ба хамгийн боломжит 174 км урттай хувилбарыг боловсруулж, ЗТХЯ-нд танилцуулсан. Мөн барилга угсралтын төлөвлөгөөг боловсруулсан.
- Зүүнбаян - Ханги чиглэлийн төмөр замын трассын 3 хувилбарын зураг төсөл болон холбогдох тооцоо судалгааг боловсруулсан.
- “УБТЗ ХНН”-ийн Рашаант-Мааньт чиглэлийн гол замын дэвсгэр болон дагуу аясын зургийг боловсруулсан.
- Зам засварын машинт анги байгуулахтай холбоотой шаардлагатай машин, механизм, хүн хүчний тооцоо болон төсөвт өртгийг боловсруулсан.
- Төмөртэй өртөөний замын аж ахуйд тогтмол арчлалт үйлчилгээ хийж ашиглалтын хэвийн найдвартай ажиллагааг ханган ажилласан.
- Төмөртэй өртөөнд Гүйцэтгэх захирлын тушаалаар паспортын үзлэгийг гүйцэтгэж, илэрсэн гэмтэл, зөрчлийн талаар төлөвлөгөө гарган галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажилласан.

#### 5.4.2 Барилгын чиглэлээр

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын 6 зөрлөгийн удирдлагын байр, орон сууцны барилгууд 100% дууссан, өртөөний 120 айлын орон сууц, өртөөний байр, гадна шугам сүлжээний хамт дуусаж, Улсын комисс хүлээн авахад бэлэн болсон.
- Замын-Үүд дэх Логистикийн төвийн ачилтын талбайн тавцанг өргөтгөх ажлыг гүйцэтгэсэн.
- Замын-Үүд дэх Бүс нутгийн логистик төвийн байгууламжид БНД-ийн дагуу хяналт тавьж, засварын байранд 5 төрлийн ажлыг гүйцэтгэгч сонгон шалгаруулж, гүйцэтгүүлсэн.

#### 5.4.3 Дохиолол, холбооны чиглэлээр

- Төмөртэй өртөө-Хандгайт хоорондын технологийн холбоо өртөө хоорондын шууд утас, галт тэрэгний захирагчийн холбоог шинээр сольж нөөц шөрмөсөнд холбосон. (Grandsteam IP telephone apparat)
- Төмөртэй өртөөний холбооны байгууламжийн тасралтгүй тэжээлийн үүсгэвэр (UPS)-ын баттареийг шинээр сольсон.
- Өртөөний тэгш, сондгой бэлчирийн тусгаарлах уулзварын дугаарыг шинэчилсэн.
- ZD-1 моторт тааруулан ширээ болон тогтоогч суурь хийсэн.
- Постын байгууламж болон хээрийн байгууламжийн газардуулгын эсэргүүцлийг хэмжиж шалгав.
- Шинээр хийсэн мотор шалгах стэнд дээр цахилгаан суман шилжүүлэгчийн моторуудын гүйдэл хүчдэлийг хэмжиж шалган цэвэрлэгээ үйлчилгээнд хамруулж байна.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шилэн кабель угсрах суурилуулах 5,6-р багцын ажлыг зохион байгуулж, Захиалагчийн хяналт тавьж дууссан.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын Дохиолол холбооны багц ажлыг Солонгосын төмөр зам компани (KNR) -тай санхүүжилтийн гэрээ байгуулахаар ажиллаж байна.

#### 5.4.4 Гүүр, хоолой, хиймэл байгууламжийн чиглэлээр

- 27 байрлалын 2427,7м гүүрийн барилга угсралтын ажлыг ерөнхий гүйцэтгэгч “УБТЗ” ХНН, туслан гүйцэтгэгч 14 аж ахуй нэгжийн бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэсэн ба галт тэрэгний хөдөлгөөнийг эхлүүлэхэд бэлэн болсон. Нийт гүйцэтгэлийн хувь 95,5 хувь байна.
- 595 байрлалын ус өнгөрүүлэх хоолойн барилга угсралтын ажил бүрэн дууссан ба Улсын комисс авахаар хүлээгдэж байна.

#### 5.4.5 Цахилгаан хангамжийн чиглэлээр

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн өртөө зөрлөгийн парк перроны гэрэлтүүлэг цахилгаан хангамжийн зураг төслийн ажлыг бүрэн гүйцэтгэж, магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулсан. “УБТЗ ХНН”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжид ажлын зургийг хүлээлгэн өгсөн.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажилласан ба ЦДАШ ажлын гүйцэтгэл 82,5%-тай байна. Дэд станцын өргөтгөл 100%, дэд станцуудын БУА 65%-ийн гүйцэтгэлтэй байна.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын 6 ширхэг ажил гүйцэтгэх түр хотхоны цахилгаан хангамжийн ажлыг хийж гүйцэтгэсэн ба төслийн барилга угсралтын ажлын хугацаанд цахилгааны хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байна.

#### 5.4.6 Төсвийн инженерийн чиглэлээр

- Далан, хоолой, гүүр, дээд бүтцийн ажлуудын гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан.
- Зам, тээврийн хөгжлийн яам болон Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын” зөвлөмжийг үндэслэн орчин үеийн машинт механизм бүхий төмөр замын, зам засварын машинт анги байгуулах ажлын эдийн засгийн үндэслэл тооцоог бэлтгэн хүргүүлсэн.
- Зам, тээврийн хөгжлийн яамны хүсэлтийн дагуу “Богд хан” төмөр замын төслийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах үнийн саналыг боловсруулсан.
- ЗХБИЦУГ-н ирүүлсэн төмөр замын дээд бүтцийг гар аргаар угсрах барилгын ажлын төсвийг дахин шинэчлэх тухай албан хүсэлтийг хянан баталгаажуулж, дэд ажлын ажлын хэсэгт танилцуулж, батлуулсан.
- “МТЗ” ТӨХК-ийн өөрийн эзэмшлийн төмөр замын зам засварын машин механизмуудыг “УБТЗ” ХНН-д түрээслэх түрээсийн гэрээний саналыг хүргүүлсэн.
- “МТЗ” ТӨХК-ийн өөрийн эзэмшлийн зам засварын машин механизмуудад ажлын зураг авалт хийж эхний тайланг танилцуулсан.

## 6. ШИНЭ ТӨМӨР ЗАМ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД

### 6.1 Төслийн хураангуй

Монгол Улсын уул уурхайн эрдэс баялгийг олборлох, боловсруулах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдох бүхий “Шинэ төмөр зам” төслийг хэрэгжүүлснээр Тавантолгойн нүүрсний ордуудаас зүүн болон өмнө зүгийн чиглэлд ойролцоогоор 1,800 км урттай төмөр замын сүлжээтэй болох юм.

“Шинэ төмөр зам” төсөл нь Тавантолгой – Сайншанд /414,6 км/, Сайншанд – Хөөт /433 км/, Хөөт – Чойбалсан – Эрээнцав /365 км/, Тавантолгой - Гашуунсухайт /267 км/, Хөөт – Бичигт (230 км), Хөөт – Нөмрөг (380 км), Нарийнсухайт – Шивээхүрэн /46,1 км/ зэрэг чиглэлүүдээс бүрдэх юм.

### 6.2 Эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан бөгөөд энэхүү бодлогын баримт бичигт Монгол улсад ойролцоогоор 5600 км төмөр замын суурь бүтцийг 3 үе шаттайгаар барихаар шийдвэрлэсэн

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын I болон II үе шатны төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон.

Мөн Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолоор, дээр дурдсан төмөр замуудын суурь бүтцийг “барих-ашиглах-шилжүүлэх” концессыг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон юм.

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барьж дуусгах, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлэхээр тусгагдсан.

Монгол улсын засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 142 дугаар тогтоолоор “Хөгжлийн зам” үндэсний хөтөлбөрийг баталсан. Уг хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт, Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замуудыг барьж дуусгах, Тавантолгой-Сайншанд-Хөөт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх, Хөөт-Нөмрөг (Сүмбэр), Сайншанд-Ханги чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлэх, Оюутолгой уурхайн салбар төмөр зам барих ажлыг эхлүүлэхээр тус тус тусгасан байна.

2009 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр БНХАУ-ын Тяньжин хотын Бинхай шинэ дүүрэгт хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх тухай санамж бичгийг БНХАУ-ын Тяньжин хотын Ардын засаг захиргаа болон Монгол улсын Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам хооронд байгуулсан.

2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Монгол улсын засгийн газрын 152 дугаар тогтоолоор Тяньжин хотын “Дунзян чөлөөт худалдааны боомт” бүсийн 10 га газарт, 50 жилийн хугацаатай Хятадын талтай хамтарсан тээвэр ложистикийн төслийг хэрэгжүүлэхэд Монголын талын төлөөллөөр



“Монголын төмөр зам” ТӨХК-ийг давуу эрхээр оролцуулах, тухайн төсөлд хөрөнгө оруулах чадамжтай хувийн хэвшлийн төлөөллийг сонгож оролцуулах ажлыг зохион байгуулахыг даалгасан. БНХАУ-ын Тяньжин хотын Дунзяны чөлөөт худалдааны боомт бүсэд тээвэр, логистикийн үйл ажиллагаа эрхлэх зориулалттай Монголын талын 49 хувь, Хятадын талын 51 хувийн хөрөнгө оруулалттай хамтарсан компани байгуулах Засгийн газрын 164 дүгээр тогтоол 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр гарсан.

Монгол улсын засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн “Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” 232 дугаар гарч, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 51-ээс доошгүй хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг байгуулахыг даалгасан.

Монгол улсын засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай” 242 дугаар тогтоолын дагуу 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдөр “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл хуралдаж “Тавантолгой төмөр зам” ХХК-ийг үүсгэн байгуулах шийдвэр гаргаж, дүрмийг баталсан. Монгол улсын засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 304 дүгээр тогтоол батлагдаж “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 66 хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК эзэмшиж, нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхийг даалгасан.

Засгийн газрын “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2019 оны 135 дугаар тогтоол, Засгийн газрын “Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай”, 2019 оны 231 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн “Монголын төмөр зам” ТӨХК-д Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих барилгын ажлын зөвшөөрлийг олгосон.

Засгийн газрын 2020 оны 117 дугаар тогтоолын дагуу “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийг үүсгэн байгуулж үйл ажиллагааг эхлүүлээд байна.

### 6.3 Хөрөнгө оруулалт

#### 6.3.1 Монгол улсын засгийн газрын хөрөнгө оруулалт

Засгийн газрын 2013 оны 1 дүгээр 26-ны өдрийн 28 дугаар тогтоолоор, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д заасан I, II үе шатны төмөр замын суурь бүтцийг барих ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн болон 2013 онд хийж гүйцэтгэх ажлыг холбогдох журмын дагуу хянан баталгаажуулж санхүүжүүлэхэд шаардагдах 55 сая ам.долларын санхүүжилтийг Хөгжлийн банкаар дамжуулан авах “ЗТЗ-Б 2013-5 тоот “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай” гэрээг 2013 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Эдийн засгийн хөгжлийн яам, Зам, тээврийн яам, Хөгжлийн банк болон “Монголын төмөр зам” ТӨХК хооронд байгуулсан. Үүнд:

Санхүүжилтийн дүн: **55 сая хүртэл ам.доллар**

Санхүүжилтийн хүү: жилийн **7,38 хувь**

Санхүүжилтийг эргэн төлөх хугацаа: 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүртэл. /Улсын төсвөөс./

Засгийн газрын 2013 оны 3 дугаар 07-ны өдрийн 82 дугаар тогтоолоор, Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс “Шинэ төмөр зам” төслийг санхүүжүүлэх 400 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн эхний ээлжинд шаардагдаж байгаа 200 сая ам.доллартай тэнцэх төгрөгийг Хөгжлийн банкаар дамжуулан авах “Г03/95/3-ТЗ-ХО 2013.16 тоот “Засгийн газрын бондын хөрөнгөөр төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай” гэрээг 2013 оны 05 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан. Үүнд:

Санхүүжилтийн дүн: **200 сая ам.доллар**, Санхүүжилтийн үндсэн хүү: **6.125 хувь**

Санхүүжилтийн хүүгийн төлөлт нь тухайн төслийг хэрэгжүүлж эхэлсний дараа оны улсын төсөвт тусгагдаж, санхүүжилтийн эх үүсвэрийн хугацаатай уялдах зарчмыг баримтлан гэрээнд заасан хуваарийн дагуу хийгдэнэ.

2016 оны байдлаар төслийн хүрээнд нийт **219.8 сая** ам.долларыг зарцуулаад байна.

Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 156 дугаар тогтоолоор, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д заасан, I, II үе шатны төмөр замын суурь бүтцийг барих ажлын “Техникийн зөвлөх (Техникийн зураг төсөл боловсруулах, FEED)” гэсэн ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулсны үндсэн дээр уг ажлын төлбөрийн үлдэгдэл төлбөр болох **3 сая ам.долларын** санхүүжилтийг Хөгжлийн банкаар дамжуулан олгохоор шийдвэрлэсэн.

Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 83 дугаар тогтоолоор, 156 дугаар тогтоолын төлбөрийн хэмжээг өөрчлөн **4.61 сая ам.долларын** төлбөрийг хяналтын зөвлөх хийсэн “Ди би Интернешнл” компанид төлөхөөр болж төлбөрийг барагдуулсан.

Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 135 дугаар тогтоолоор, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор 1 удаагийн, хүүгүй, 20 хүртэлх жилийн хугацаатай 750 тэрбум төгрөгийн үнэт цаасыг нэрлэсэн үнээр хаалттай хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК худалдах, “Эрдэнэс-Тавантолгой” ХК худалдан авах замаар санхүүжүүлэлтийг шийдвэрлэсэн.

Санхүүжилтийн дүн: **750 тэрбум төгрөг**,

Санхүүжилтийн хүү: **Хүүгүй**

Санхүүжилтийн эргэн төлөх хугацаа: **20 хүртлэх жилийн хугацаатай** /"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны хуримтлагдсан ашгаас/

**6.3.2 Өөрийн хөрөнгө оруулалтын санхүүжилт**

"МТЗ" ТӨХК нь 2017 оны 3 дугаар улиралд "Шинэ төмөр зам" төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх чиглэлээр дараах байгууллагуудтай хамтарч ажилласан. Үүнд:

Хөрөнгө оруулагч	Тайлбар
"МАК" ХХК	Нарийнсухайт-Шивээхүрэн-Сэхэ чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын ТЭЗҮ-г боловсруулах, ажлын зураг төсөл, инженерийн тооцоо хийх, барилгын ажлыг санхүүжүүлэх, төмөр замын суурь бүтэц ашиглах, шилжүүлэх, өмчлөх тухай хамтран ажиллах санамж бичгийг 2015 оны 07 дугаар сарын 21-ний өдөр ЗТХЯ болон "МАК" ХХК-тай байгуулсан.
"Гоби Коул энд Энержи" ХХК	2016 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Ерөнхий хэлэлцээр байгуулсан. Ерөнхий хэлэлцээрийн хүрээнд: <ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий хэлэлцээрийн хүрээнд төслийг хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулсан.</li> <li>- 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдөр тус хэлэлцээрийг сунгасан.</li> </ul>
Чайна Рэйлвэй Машинери Инженеринг групп ХХК	Хөөт-Бичигт чиглэлийн төмөр зам, Хөөтийн шилжүүлэн ачих байгууламжийн барьж байгуулах сонирхолтой. Санамж бичгийн хүрээнд Хөөт-Бичигт чиглэлийн төмөр зам, Хөөтийн шилжүүлэн ачих байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.
"БНСУ-ын Төмөр замын удирдах газар"	2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Төмөр замын төсөлд хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулсан. Тус санамж бичгийн хүрээнд: <ul style="list-style-type: none"> <li>- Монгол улсын төмөр замын мастер төлөвлөгөө</li> <li>- Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын ТЭЗҮ</li> <li>- Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын төмөр замын техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулах;</li> </ul>
БНХАУ-ын "Хуили инвестмент фонд менежмент" ХХК	БНХАУ-ын "Хуили инвестмент фонд менежмент" ХХК-тай Сайншанд-Хөөт, Чойбалсан-Бичигт чиглэлийн төмөр замын төслүүдэд Хамтран ажиллах санамж бичиг, Нууц хадгалах гэрээ, Хамтын ажиллагааны Ерөнхий Хэлэлцээр байгуулсан. <ul style="list-style-type: none"> <li>- "Монголын төмөр зам" ТӨХК, "HuiLi Investment Fund Management Co.Ltd (HIFM)" компанийн хооронд 2019 оны 8-р сарын 20-нд Санамж бичиг байгуулсан.</li> <li>- "Монголын төмөр зам" ТӨХК, "HuiLi Investment Fund Management Co.Ltd (HIFM)" компанийн хооронд 2020 оны 1-р сарын 16-нд Хамтын ажиллагааны Ерөнхий Хэлэлцээр байгуулсан.</li> <li>- "HuiLi Investment Fund Management Co.Ltd (HIFM)" компаниас төслийн эхний шатны хөрөнгө оруулалт, санхүүжилтэд шаардагдах 2,3 тэрбум ам.долларын хөрөнгө бэлэн байгааг илтгэсэн албан захидлаа холбогдох банк санхүүгийн бичиг баримтын хамт ирүүлсэн.</li> </ul>



Siemens	2020 оны 2-р сард хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Хамтын ажиллагааны хүрээнд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дохиолол холбооны багц ажил бусад ажлуудыг санхүүжүүлэх зорилгоор ОХУ-ын "Росэксимбанк"-аас хөнгөлөлттэй нөхцлөөр 10 жилийн хугацаатай 150 сая Евро-ийн зээл олгох боломжтой тухай саналаа ирүүлсэн.
Huahan International Trading	2020 оны 4-р сарын сарын 23-нд ирүүлсэн албан захидалдаа, зам төмөр, бэхэлгээ, суман шилжүүлэг, дохиолол холбоо, зүтгүүр, вагон зэрэг худалдан авалтанд зориулж <b>350-500 сая ам долларын</b> зээл олгох боломжтойгоо илэрхийлсэн.
Norinko International Cooperation Ltd	2020 оны 4-р сарын 29-ны өдрийн албан захидалдаа Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар жилдээ 5 сая тн нүүрс тээвэрлүүлэх сонирхолтой бөгөөд энэхүү тээврийн хөлснөөс урьдчилгаа байдлаар төмөр замын бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх боломжтойгоо илэрхийлсэн. Хамтын ажиллагаа санамж бичиг байгуулах түвшинд явж байна.

Компани нь дээр дурдагдсан хөрөнгө оруулалтын чиглэлээр ажлуудын явц болон шаардлагатай мэдээллийг Зам, тээврийн хөгжлийн яаманд тухай бүр танилцуулж чиглэл авч ажиллаж байна.

#### 6.4 Суурь бүтэц барих чиглэлээр хийгдэж буй ажлууд

##### 6.4.1 "Тавантолгой – Гашуунсухайт" чиглэлийн төмөр зам

2019 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Монгол улсын Ерөнхий сайдын 176 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын 33 дугаар тушаал батлагдсан. Уг тушаалд Монгол улсын Ерөнхий сайдын 176 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн шийдвэрийн дагуу тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл, холбогдох тооцоо судалгааг шинэчлэн боловсруулахыг "Монголын төмөр зам" ТӨХК-ийн ТУЗ-д тус зөвшөөрсөн. 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдөр "Бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай" Зам, тээврийн хөгжлийн сайдын 40 дүгээр тушаал батлагдсан. Үүнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай 2018 оны 242 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэхээр зааж, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Цэнгэлд хариуцуулан тогтоосон хугацаанд чанартай хийж гүйцэтгэх ажлыг уялдуулан зохион байгуулж удирдлагаар хангахыг үүрэг болгосон.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 33, 40 дүгээр уг тушаалыг тус тус үндэслэн 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Гүйцэтгэх захирлын тушаалаар техник эдийн засгийн үндэслэл шинэчлэх ажлын хэсэг байгуулагдан ажилласан. /ТЭЗҮ шинэчлэх ажлын явц - 50%/

2019 оны Засгийн газрын 304 дүгээр тогтоолын дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийг "Тавантолгой төмөр зам" ХХК-д олгосон. Тус чиглэлийн төмөр замын төсөлд ашиглагдаж байсан Main, Middle, Чонун кемпууд, холбогдох бүх баримт бичиг, эд хөрөнгө, бараа материал мөн төмөр замын барилгын далан, ухмал, гүүр хоолойн ажлын хэмжээг шинэчлэн тодорхойлж "Тавантолгой төмөр зам" ХХК-д хүлээлгэн өгсөн.

##### 6.4.2 Зүүн босоо коридор "Чойбалсан - Хөет - Бичигт" чиглэлийн төмөр зам

БНХАУ-ын "Хуили инвестмент фонд менежмент" ХХК-тай Сайншанд-Хөет, Чойбалсан-Бичигт чиглэлийн төмөр замын төслүүдэд хамтран ажиллах санамж бичиг, нууц хадгалах гэрээ байгуулсан.

##### 6.4.3 "Зүүнбаян - Ханги"

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/64 тоот тушаалаар Зүүнбаян-Хангийн чиглэлийн төмөр замын төслийн техник-эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.

Хятадын "Си-Ар-И-Си" ХХК-ийн боловсруулсан Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын Техник-эдийн засгийн үндэслэлийг судалж, холбогдох инженер мэргэжилтнүүдээс санал шүүмжийг авч нэгтгэн боловсруулж ТЭЗҮ-д тусгуулах тухай албан тоотоор хүргүүлсэн.

2020 онд ҮАБЗ-ийн зөвлөмж гарсан.

#### 6.4.4 “Нарийнсухайт - Шивээхүрэн” чиглэлийн төмөр зам

Зам, тээврийн сайдын 2014 оны 1/4686 тоот мэдэгдлийн дагуу “Төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын I, II үе шатанд хамаарах Нарийнсухайт – Шивээхүрэн – Сэхэ чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилга угсралтын ажлыг “МТЗ” ТӨХК болон “МАК” ХХК-ийг хамтран гүйцэтгэх үүрэг өгсний дагуу “МТЗ” ТӨХК нь Нарийнсухайт-Шивээхүрэнгийн чиглэлийн төмөр замыг БНХАУ-ын Сэхэ боомттой холбосон төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын ТЭЗҮ-ийг боловсруулах, ажлын зураг төсөл, инженерийн тооцоо хийх, барилгын ажлыг санхүүжүүлэх, төмөр замын суурь бүтэц ашиглах, шилжүүлэх, өмчлөх тухай хамтран ажиллах Санамж бичгийг 2015 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Зам, тээврийн яам, “МАК” ХХК-тай байгуулсан.

Санамж бичгийн дагуу “МАК” ХХК-ийн захиалгаар “Мөнгөн зөрлөг” ХХК-ийн хийсэн “Нарийнсухайт-Шивээхүрэн” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох мэргэжилтнүүдээс өгсөн санал, шүүмжүүдийг нэгтгэн албан бичгээр “МАК” ХХК болон ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн “Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах арга хэмжээний тухай” 232 дугаар тогтоол гарч, “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-тай хамтарсан төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулахыг даалгасан.

Засгийн газрын тогтоолын дагуу “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг байгуулах Хувьцаа эзэмшигчдийн гэрээний төслийг боловсруулахад баримтлах Зөвлөмж чиглэлийг ТӨБЗГ-аас авч, Хувьцаа эзэмшигчдийн гэрээний төслийг боловсруулан, “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-д хүргүүлж, хоёр тал гэрээний нөхцөлүүд дээр тохиролцохоор харилцан санал солилцож, мөн төслийн санхүүжилтийг эргэн төлөх, цэвэр ашгийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилах зэрэг гэрээний гол нөхцөлүүд дээр хэлцэл хийх боломжит хувилбаруудыг боловсруулан ажилласан.

Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын царигийг 1435 мм-ээр тогтоох тухай УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалыг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. УИХ-ын ЭЗБХ-ны 2019 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн хурлаар хэлэлцэж дэмжсэн.

Гэвч УИХ-аар хэлэлцэгдэх нь хойшлогдож, УИХ-ын 2020 оны 64 дүгээр тогтоол цуцлагдаж, 1520 мм царигаар баригдах болсон.

#### 6.4.5 “Тавантолгой - Зүүнбаян” чиглэлийн төмөр зам

Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоол батлагдсан. Уг тогтоолын дагуу тус чиглэлийн төмөр замын тооцоо судалгааг шинэчлэн, “Шинэ төмөр зам” төслийн Техник эдийн засгийн үндэслэлийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын хэсгийн тодотголыг боловсруулж, 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг Зам тээврийн хөгжлийн төв магадлал хийж баталгаажуулсан.

Мөн төслийн шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор нэг удаагийн, хүүгүй, 20 хүртэлх жилийн хугацаатай 750 тэрбум төгрөгийн үнэт цаасыг нэрлэсэн үнээр хаалттай хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК худалдах, “Эрдэнэс-Тавантолгой” ХК худалдан авах замаар санхүүжүүлэлтийг шийдвэрлэсэн.

##### **Тайлан мэдээ хүлээн авах, хянах**

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн барилга угсралтын ажилбар бүрийн явц мэдээ, тайланг хүлээн авч, холбогдох инженерүүдээр хянуулан ажиллаж байна. Төмөр замын төслийн хэрэгжилтэд хяналт тавих тухай Гүйцэтгэх захирлын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/19 тоот тушаалын дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд хийгдэж байгаа зөвлөх болон гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг хүлээн авч холбогдох Хяналтын багуудаар хянуулж “Тайлан хянан баталгаажуулсан тухай” актаар баталгаажуулсаны үндсэн дээр санхүүжилт олгох эрх нээгдэж Санхүү, эдийн засгийн газарт шилжүүлэн ажилласан. Үүнд:

- Балластын үйлвэрлэл-1 ААН- нийт 1 гүйцэтгэлийн тайлан
- Бетон дэрний үйлдвэрлэл-2 ААН нийт-2 гүйцэтгэлийн тайлан
- Газар шорооны ажил-2 ААН-нийт 4 гүйцэтгэлийн тайлан
- Барилга, өртөөний барилга-2 ангийн -2 гүйцэтгэлийн тайлан
- Гүүрийн барилга -5 ААН- нийт 5 гүйцэтгэлийн тайлан
- Геодезийн хяналт-3 ААН- нийт 10 гүйцэтгэлийн тайлан
- Материалын хяналт-1 ААН- нийт 5 гүйцэтгэлийн тайлан
- Эрчим хүчний ажил-5 ААН- нийт 5 гүйцэтгэлийн тайлан
- Шилэн кабель-6 ААН-нийт 6 гүйцэтгэлийн тайлан
- Дээд бүтцийн ажил-1 ААН-нийт 17 гүйцэтгэлийн тайлан.

10 чиглэлээр үйл ажиллагаа явуулсан нийт 28 аж ахуйн нэгжийн 55 гүйцэтгэлийн тайланд хяналт тавьж, холбогдох албан тушаалтнуудаар баталгаажуулан санхүүжилт хийхэд бэлэн болгосон.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилтийн тухай тайлан, танилцуулга, илтгэл, шторк, анонс, судалгаа, шинжилгээний материалуудыг бэлтгэн Ерөнхийлөгч,

Ерөнхий сайд, УИХ-ын дарга, УИХ-ын гишүүд, Эдийн засгийн байнгын хорооны гишүүд, Засгийн газар, ЗТХЯ, Гүйцэтгэх захирал болон удирдлагыг мэдээ мэдээллээр тогтмол ханган ажилласан.

#### **Барилга угсралтын ажлын мэдээ авах, тайлагнах**

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн барилга, угсралтын ажлын явцад тогтмол хяналт тавин, холбогдох байгууллагуудыг мэдээллээр ханган ажилласан. Барилга угсралтын ажлын явц 2021 оны хагас жилийн гүйцэтгэлээр:

Ус хангамж - Төслийн хүрээнд нийт 43 худаг өрөмдөж, тоноглохоор төлөвлөсөн бөгөөд нийт 5 компанитай гэрээ байгуулан 2020 оны 6 дугар сард ашиглалтад хүлээн авсан.

Өртөө зөрлөгийн барилга, байгууламжийн барилга угсралтын ажил- 1 өртөө, 6 зөрлөгийн барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байна. Зөрлөгүүдийн барилга угсралтын ажил дуусаж, барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар Улсын комисст хүлээлгэн өгсөн. Тавантолгой өртөөний барилга угсралтын ажил 98%-ийн гүйцэтгэлтэй байна.

Далан - Доод бүтцийн барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр ЗХЖШ, туслан гүйцэтгэгч 49 компанитай хамтран ажиллаж байгаа бөгөөд 25.1 сая м.куб газар шорооны ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан.

Хоолой – Нийт 595 байршилд ус зайлуулах хиймэл байгууламж төлөвлөн ЗХ-ний 9 анги, туслан гүйцэтгэгч 25 аж ахуйн нэгж барилга угсралтын ажлыг 100% гүйцэтгэсэн.

Гүүр - Нийт 2427.7 у/м бүхий 27 ширхэг гүүр барихаар төлөвлөгдсөн бөгөөд ерөнхий гүйцэтгэгчээр “УБТЗ” ХНН ажиллаж байна. Гүүрийн ажил 96%-ийн гүйцэтгэлтэй байна.

Балласт - Төсөлд шаардлагатай 890 мянган м.куб балластыг үйлдвэрлүүлэхээр тусгай зөвшөөрөл бүхий компаниудыг сонгон шалгаруулж, Дэд ажлын хэсгийн зөвлөмжөөр 6 байгууллагатай гэрээ байгуулан, 806.2 мянган м.куб балласт үйлдвэрлэсэн. Балласт үйлдвэрлэлийн ажил 90.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Гэрээ байгуулсан:

“Санчир инженеринг” ХХК

“Интернэйшнл роуд” ХХК

“Боржигон хос зам” ХХК

ЗХЖШ-ны Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газар

“УБТЗ” ХНН

“МКАТ” ХХК

Эрчим хүч - Нийт 416,1 км төмөр замын трассын дагуу 455.5 км цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/ -ын барилга угсралтын ажил хийгдэхээр төлөвлөсөн. Эрчим хүчний ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “УБТЗ” ХНН, туслан гүйцэтгэгч 10 компани ажиллаж байна. Эрчим хүчний ажил 87.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төмөр бетон дэр – Төслийн хэмжээнд 842.6 мянган ширхэг төмөр бетон дэрний үйлдвэрлэлийг үндэсний 3 компани бүрэн гүйцэтгэсэн.

Үе угсрах - Төмөр замын үе угсрах, үе тавих ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “УБТЗ” ХНН, туслан гүйцэтгэгчээр ЗХЖШ ажиллаж байна. Нийт 430 км үе угсараад байна.

Дохиолол холбоо - Төмөр замын 2 талаар трассын дагуу шилэн кабель 30-50 метрийн зайтай, төмөр замын 2 талаар цагираг хэлбэрээр нийт 871 км шилэн кабель угсарч суурилуулна. Уг ажлыг 7 аж ахуйн нэгж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 96 хувьтай байна.

Төмөр зам гар, механик аргаар барих технологи

Тодорхой шалтгаануудын /зам төмрийн нийлүүлэлт гэх мэт/ улмаас үүссэн болон үүсэж болох хоцрогдлыг арилгах үүднээс цаашид Гар, механик хослуулан төмөр замын дээд бүтцийг угсрах ажлын аргачлал болон төсвийг Инженер, технологийн газартай хамтран боловсруулж, энэхүү аргачлалаар төмөр замын дээд бүтцийг угсрах мөн үүнд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг худалдан авах болон дотооддоо үйлдвэрлэж төмөр зам тавиад байна.

2020 оны 6-р сарын 15-ны өдөр БНСУ-ын “Грийн тех” компанитай төмөр замын тусгай зориулалтын техник, хэрэгсэл бэлэглэх “Бэлэглэлийн гэрээ” байгуулж, уг гэрээний дагуу төмөр замын гидравлик хавчаар, төмөр замын гидравлик зам өргөх машин /чиг татагч/, тэргэнцэр зэрэг нийт 70 мянган ам долларын үнэ бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч төмөр замыг гар, механик аргаар барихад ашиглаж байна.

#### **6.4.6 Тяньжин “Тээвэр логистикийн төв” төсөл**

Гүйцэтгэх захирлын 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/43 тоот тушаалаар “Хятад-Монголын олон улсын логистикийн бүс” ХХК-ийн БНХАУ-ын Тяньжин хотын Дунзяны чөлөөт худалдааны боомт бүсэд эрхлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийг тодорхойлох, тэдгээрийг хэрэгжүүлэхэд хоёр талын үүрэг оролцоо, хамтын ажиллагааны чиглэлээр “Тяньжин порт групп”-тэй цахим ажлын уулзалт, хэлцлийг хийх, БНХАУ дахь хамтарсан компанийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

**Бусад:**

Гүйцэтгэх захирлын 2021 оны 03-р сарын 05-ны өдрийн А/23 тоот тушаалаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд ЗХЖШ-тай байгуулсан Төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх АГГ-19/10094/28 дугаар гэрээний хэрэгжилтийг ЗХЖШ-ын БИЦУГ-тай хамтран дүгнэх Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг хэд хэдэн удаа хуралдаж, Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн төмөр замын трассын дагуу явж ажилтай газар дээр нь танилцаж, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн актын төсөл дээр ажиллаж байна.

“Шинэ төмөр зам” төсөлтэй холбоотой хигдэж буй ажлууд:

#### **Судалгаа шинжилгээ хийх ажлын хүрээнд:**

- ЗТХСайдын 2020 оны А/158 тоот тушаалаар “Төмөр замын дээд бүтцийг барих угсрах түүний төсөвтэй холбоотой техникийн шаардлага, үнэлгээ, заавар, норм дүрэм боловсруулан батлуулах үүрэг бүхий ажлын хэсэг 2021 онд дараахь бичиг баримтуудыг боловсруулж бэлэн болгосон. Үүнд:
  - Танилцуулга
  - Төмөр замын замын дээд бүтцийг барих ажлын заавар
  - Төмөр замын замын дээд бүтцийг шинээр угсарч барих технологийн аргачлал
  - Төмөр замын зам, гүүрийн зураг төсөл боловсруулах дүрэм
  - Төмөр замын замын дээд бүтцийн барилгын ажлын суурь норм ба дүрэм
  - Төмөр замын замын дээд бүтцийн барилгын ажлын төсөв зохиох дүрэм.Эдгээрийг ЗТХЯ-ны ШУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, ЗТС баталсан. Стандартын хэлбэрт шилжүүлэн батлуулахаар ажиллаж байна.
- “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/50 дугаар тушаалаар “Шинэ төмөр зам” төслийн Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар ТЭЗҮ-ийг урьдчилсан байдлаар боловсруулж Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж бэлэн болгоод байна.
- ТӨБЗГ-ын 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А-1/765 тоот албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу БНХАУ-ын төмөр замын тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч “CRRC YANGZE” ХК-иас нүүрсийг чингэлгээр тээвэрлэх үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд “Хил дамнасан агаарын төмөр замын чингэлэг тээврийн ухаалаг системийг нэвтрүүлэх төсөл”-ийн хамтарсан ажлын хэсэг байгуулан Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтуудад хэрэгжүүлэхээр төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажил хийгдэж байна.

## **7. СТАНДАРТЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖИЛ**

Зам тээврийн салбарын стандарт шинэчлэлийн ажлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн албан даалгаврын дагуу олон улсын стандартыг нутагшуулах, орчуулах ажлын хүрээнд “Хөдлөх бүрэлдэхүүний тормозны ажиллагааны систем”, “Зам засварын машин механизм”, “Бетон дэр”, “Замын трассын зураг төсөл”, “Зам төмрийн геометр хэмжээс” зэрэг стандартуудын орчуулгын ажлыг гүйцэтгэж тухай бүр яаманд явцын талаар мэдээлэл хүргүүлдэг ба бусад аж ахуйн нэгжүүдээс орчуулан ирүүлсэн стандартын төслүүдэд мөн санал өгч ажиллаж байна.

## **8. ТЭЭВЭР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД**

### **8.1 Төмөртэйн төмөр замын үйл ажиллагаа**

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийн концессын гэрээг “Кью Эс Си” ХХК-д шилжүүлж тус компани 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Эдийн засгийн хөгжлийн яамтай концессын гэрээг байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 364 дүгээр тогтоолоор “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлэх “Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэй ордоос “Болдтөмөр Ерөө Гол” ХХК-ийн Хандгайт өртөө хүртэлх 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих” концессын “барих-ашиглах-шилжүүлэх” төрлийг концессын “барих-шилжүүлэх” төрөл болгон өөрчилсөн. Тус төмөр зам нь Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн Төмөртэй уурхайн бүтээгдэхүүнийг зөөвөрлөх зориулалт бүхий уурхайн төмөр зам юм. Улсын комисс 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 02/18/15 тоот актаар хүлээн авсан.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 77 дугаар тогтоолоор тус төмөр замыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн өмчид шилжүүлэх шийдвэр гарсан.

2016 оны 06 дугаар сарын 07-ны өдөр төмөр замын гүйцэтгэлийн баримт бичгүүдийг, 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдөр суурь бүтэц, зам, талбай, дохиолол холбооны байгууламж, тоног төхөөрөмж зэрэг биет хөрөнгүүдийг гүйцэтгэгч компанитай хамтран тус тус акт үйлдэн хүлээлцсэн.



**Байршил, чиглэл:** Энэхүү төмөр зам нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “БТЕГ” ХХК-ийн Баянгол төмөр замын эцсийн өртөө буюу Хандгайт өртөөнөөс Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутаг дэвсгэр дэх “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн харьяа Төмөртэйн уурхай хүртэл тавигдсан төмөр зам юм.

**Төмөр замын хүчин чадал:** Хандгайт-Төмөртэй чиглэлийн төмөр замын шугамын гол зам нь 23.4 км урттай, өртөөний хүлээн авах явуулах замууд, нийтийн хэрэгцээний зам, нефтийн бүтээгдэхүүн буулгах зам болон бусад замуудын урт нь 10 км юм. Хандгайт-Төмөртэй чиглэлийн төмөр зам нь MNS 6229:2010 стандартын дагуу хөдлөх бүрэлдэхүүний нэг голд ногдох ачаалал 25 тонн, ачааны галт тэрэгний дээд хурд 70-80 км/ц байх шаардлагыг хангасан. Төмөртэй өртөө нь тус бүр 25 вагоны багтаамжтай ачилтын 4 зам, 4 вагон пүү, ачилтын 2 талбайтай байгуулагдахаар төлөвлөгдсөн. Гаалийн байгууллагын шаардлагын дагуу Гаалийн хяналтын талбайд авто пүү суурилуулах шаардлагатай болсон тул 2021 оны 1-р улиралд тендер зарлан, гүйцэтгэх аж ахуйн нэгжийг сонгосон бөгөөд барилга, угсралтын ажил гүйцэтгэх явцдаа байна.

#### Үйл ажиллагаа:

Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм болон холбогдох бусад дүрэм, журамд нийцүүлэн тээвэрлэлтийг шуурхай, үр ашигтай зохион байгуулах үүднээс Гаалийн байгууллага, зэргэлдээ суурь бүтэц эзэмшигч, ачаа илгээгч байгууллага, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай тус тусын зориулалтын дагуу гэрээ байгуулан ажиллаж байна.

Дархан-Уул аймаг дахь Гаалийн газартай Гаалийн хяналтын бүс эзэмшигчийн гэрээний дагуу хамтран ажиллаж байна. Дарханы гаалийн газартай байгуулсан 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан ГБЭ-19/9589/14 тоот гэрээний сунгалтын хугацаа 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болж байгаа тул гэрээ сунгах хүсэлтээ Дархан-Уул аймгийн Гаалийн газарт хүргүүлсэн болно.

Мөн төмөр замын ашиглалт, арчлалт, ачаа болон хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн, мэдээллийг зохион байгуулахад шаардлагатай батлагдсан журам, заавар, технологийн процессыг мөрдөн ажиллаж байна.

Төмөртэй өртөөнд ашиглаж буй Техник захирамжийн актыг 2020 оны 02-р сарын 20-ны өдөр, Технологийн процессыг 2020 оны 03-р сарын 6-ны өдөр шинэчлэн батлуулсан.

Төмөртэй-Хандгайт чиглэлийн 23.4 км замд ачаа илгээгчийн захиалгат ачааны тээвэрлэлтийг зохион байгуулахад, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр 1, тээвэр зохион байгуулалтын чиглэлийн 24, вагоны техник үйлчилгээний чиглэлийн 14, хөдлөх бүрэлдэхүүний чиглэлийн 20, дохиолол холбооны чиглэлийн 5, зам засварын чиглэлийн 16, аж ахуйн чиглэлийн 12 ажилтан буюу 3 ээлжийн нийт 92 хүний бүтэцтэй ажиллаж байна.

#### Тээвэрлэлт:

Ачаа урсгалын эрэлтээс шалтгаалан одоогийн байдлаар тээвэрлэлтэд Эволюшн болон СКD4B маркийн гол замын 3, сэлгээний 1 зүтгүүр, ачилтын 4 зам, 2 талбай, 2 вагон пүү ашиглагдаж байна.

2021 оны байдлаар “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК, “Ган хүдэр Орд” ХХК, “Талын хишиг майнинг” ХХК, “Мидас ложистикс” ХХК, Бат Мөнх Бат Констракшн ХХК, “Жи-Ар Капитал” ХХК, “Ган Эрдэс Хүдэр” ХХК, “Их-Уул менежмент” ХХК, “Херо хүдэр” ХХК, “Аппалуза” ХХК, “Говийн эко хүнс” ХХК, “Нэст” ХХК, “Ган бөмбөлөг ундарга” ХХК, “Феррум металл Монголия” ХХК, “Альфа караван” ХХК, “Гэрэлт хос болор” ХХК, “Хангарьд сити” ХХК гэсэн компаниудтай ачаа тээвэрлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн “Төмөр замын зураг төслийн институт” ХХК-тай вагон хадгалалт, таталт тавилт, сэлгээ хийх, тээвэрт бэлдэх тухай гэрээг байгуулан ажиллаж байна. Хандгайт дахь өөрийн эзэмшлийн талбайг “Жи-Ар Капитал” ХХК -тай түрээсийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Цаашид импорт, экспорт болон дотоодын ачаа тээвэрлүүлэх сонирхолтой аж ахуйн нэгжтэй ачаа тээвэрлэх, Хандгайт дахь өөрийн эзэмшлийн ачилтын талбайг ашиглуулах чиглэлээр тухай бүрт нь хамтран ажиллаж, тээвэрлэлтийг гүйцэтгэж байна.

2021 онд тээвэрлэсэн ачааг тээвэрлүүлэгч байгууллагаар нь жагсаавал:

Тээвэрлүүлэгч байгууллага	Ачааны нэр	Ачилт		Буулгалт		Нийт	
		Вагон тоо	Жин тонн	Вагон тоо	Жин тонн	Вагон тоо	Жин тонн
“Дархан Төмөрлөгийн Үйлдвэр” ХК	төмрийн хүдэр	2298	154203,63	6	89,94	2304	154293,57

“Ган хүдэр орд” ХХК	төмрийн хүдэр	45	3036,00			45	3036,00
“Талын хишиг майнинг” ХХК	төмрийн хүдэр	4347	291358,98			4347	291358,98
“Мидас ложистикс” ХХК	төмрийн хүдэр	700	47835,00			700	47835,00
“Бат Мөнх Бат”Констракшн ХХК	төмрийн хүдэр	250	17202,00			250	17202,00
“Жи Ар Капитал” ХХК	төмрийн хүдэр	600	40614,35			600	40614,35
“Ган бөмбөлөг ундарга” ХХК	төмрийн хүдэр	1404	94890,37			1404	94890,37
“Ган Эрдэс Хүдэр” ХХК	төмрийн хүдэр	250	17018,00			250	17018,00
“Их-Уул менежмент” ХХК	төмрийн хүдэр	550	37107,00			550	37107,00
“Аппалуза” ХХК	төмрийн хүдэр	300	20642,00			300	20642,00
“Гэрэлт хос болор” ХХК	төмрийн хүдэр	600	41110,00			600	41110,00
“Хангарьд сити” ХХК	төмрийн хүдэр	300	20601,00			300	20601,00
“Херо хүдэр” ХХК	төмрийн хүдэр	583	39536,91			583	39536,91
“Говийн эко хүнс” ХХК	төмрийн хүдэр	400	27589,00			400	27589,00
“Нэст” ХХК	төмрийн хүдэр	150	10346,00			150	10346,00
“Бьюроу веритас” ХХК	чингэлэг сууц	1	3.30			1	3.30
“Платиниум их өргөө констракшн” ХХК	ачаа өргөгч			2	35,32	2	35,32
“МТЗ” ТӨХК	нүүрс			4	254,00	4	254,00
	<b>Бүгд:</b>	<b>12778</b>	<b>863093,54</b>	<b>12</b>	<b>379,26</b>	<b>12790</b>	<b>863472,80</b>

#### Ачилтын төлөвлөгөө

Сар	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	144384,00	95151,00	65,90
2	130411,00	111522,30	85,52
3	144384,00	172009,40	119,13
<b>1-р улирал</b>	<b>419179,00</b>	<b>378682,70</b>	<b>90,34</b>
4	139726,00	160407,86	114,80
5	144383,00	181049,42	125,40
6	139726,00	142953,56	102,31
<b>2-р улирал</b>	<b>423835,00</b>	<b>484410,84</b>	<b>114,29</b>
<b>Хагас жилийн дүн:</b>	<b>843014,00</b>	<b>863093,54</b>	<b>102,38</b>

#### Төмөртэй өртөөний ашиглалтын ажлын үзүүлэлтүүд

2021 оны эхний 6 сараар

Д/д	Тээврийн үзүүлэлтүүдийн төрөл	Хэмжих нэгж	2020	2021 он			2021/2020
				төлөвлөгөө	биелэлт	хувь	

1	Хоногийн ажил						
1.1	Ачилт /вагоноор/	хон.дундаж	76.03	69.51	70.60	101.56%	92.86%
1.2	Ачилт /тонноор/	тонн	949,986.74	843,014.00	863,093.54	102.38%	90.85%
1.3	Ачаатай хүлээн авсан вагон	хон.дундаж	0.06	0.07	0.07	92.31%	109.69%
1.4	Ачаатай хүлээлгэн өгсөн вагон	хон.дундаж	76.03	63.74	64.24	100.79%	84.50%
1.5	Буулгалт	хон.дундаж	0.06	0.07	0.07	92.31%	109.69%
2	Замын хэмжээний ажил	хон.дундаж	76.09	69.59	70.66	101.55%	92.87%
3	Статик даац	тонн	68.66	67.00	67.55	100.81%	98.38%
4	Динимик даац /ачаатай вагон/	тонн	68.62	66.96	67.50	100.81%	98.37%
5	Хоногийн тоо /тайлант хугацаа/	хоног	182.00	181.00	181.00	100.00%	99.45%
6	Тээвэрлэсэн ачааны хэмжээ	тонн	950,274.78	773,414.00	785,751.45	101.60%	82.69%
6.1	Оруулалт /БТЕГ-ээс хүлээн авсан ачаа/	--"--	288.04	400.00	379.26	94.82%	131.67%
6.2	Гаргалт /БТЕГ-д хүлээлгэн өгсөн ачаа/	--"--	949,986.74	773,014.00	785,372.19	101.60%	82.67%
6.3	Орон нутаг	--"--	40,081.81	100,000.00	128,520.58	128.52%	320.65%
6.4	экспорт	--"--	909,904.93	673,014.00	656,851.61	97.60%	72.19%
	хандгайт		0.00	70,000.00	77,721.35	111.03%	
7	Ачаа эргэлт	сая тн.км	22,236,429.85	18,097,887.60	18,386,583.93	101.60%	82.69%
7.1	Оруулалт	--"--	6,740.14	9,360.00	8,874.68	94.82%	131.67%
7.2	экспорт	--"--	21,291,775.36	15,748,527.60	15,370,327.67	97.60%	72.19%
7.3	Орон нутаг	--"--	937,914.35	2,340,000.00	3,007,381.57	128.52%	320.65%
10	Ачааны вагоны ажлын парк	абсолют	19,382.80	17,627.80	17,901.20	101.55%	92.36%
		хон.дундаж	106.50	97.39	98.90	101.55%	92.87%
10.1	үүнээс: Хоосон вагон	абсолют	5,556.80	5,058.80	5,135.20	101.51%	92.41%
		хон.дундаж	30.53	27.95	28.37	101.51%	92.92%
11	Замын хэмжээний ажил	абсолют	13,848.00	12,595.00	12,790.00	101.55%	92.36%
12	Ачилт /вагоноор/	--"--	13,837.00	12,582.00	12,778.00	101.56%	92.35%
13	Ачаатай хүлээн авсан вагон	--"--	11.00	13.00	12.00	92.31%	109.09%
14	Ачаатай хүлээлгэн өгсөн вагон	--"--	13,837.00	11,537.00	11,628.00	100.79%	84.04%
	хандгайт ачсан вагон		0.00	1,045.00	1,150.00	110.05%	
15	Буулгасан вагон тоо	абсолют	11.00	13.00	12.00	92.31%	109.09%
16	Вагон эргэлт	хоног	1.60	1.50	1.50	100.00%	106.67%
17	АНАВСЗ	час	15.00	15.00	15.00	100.00%	100.00%
18	ОНВСЗ	час	15.00	15.00	15.00	100.00%	100.00%
19	Бохир тонн километр	млн.	37,123,836.52	30,506,564.53	30,895,124.65	101.27%	83.22%

19.1	Үүнээс: Ачааны хөдөлгөөнд	млн.	37,123,836.5 2	30,506,564 .53	30,895,124. 65	101.27 %	83.22%
19.3	аж ахуйн хөдөлгөөнд	--"--	0.00	0.00	0.00		
20	Цэвэр тонн километр	млн.	22,236,429.8 5	18,097,887 .60	18,386,583. 93	101.60 %	82.69%

Цаашид “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХК-ийн хэрэгжүүлж буй төсөл болох “Уул уурхай, металлургийн цогцолбор үйлдвэр” баригдсанаар тус үйлдвэрлэлийн түүхий эдийн хэрэгцээг хангах зорилгоор тус чиглэлийн төмөр замаар Дархан-Уул аймаг руу төмрийн хүдрийн тээвэрлэлт хийгдэх юм.

## 8.2 Замын-Үүд дэх “Шилжүүлэн ачих цогцолбор-1”-ийн үйл ажиллагаа

Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдсан Дорноговь аймгийн Замын-Үүд дэх Шилжүүлэн ачих цогцолбор-1 нь 1995 оны 12 дугаар сард байгуулагдсан.

Шилжүүлэн ачих цогцолбор 1 байгууламж нь Монгол Улсын Замын-Үүд боомтоор дамжин өнгөрөх экспорт, импортын болон транзит ачаа тээврийн урсгалыг тасралтгүй жигд, хэвийн хангах, ачааны бүрэн бүтэн байдлыг аж ахуйн нэгж байгууллагууд болон олон улсын өмнө хариуцан ажилладаг чухал үүрэгтэй онцгой объект юм.

Монгол улсын Төрийн өмчийн хорооны 2008 оны 225 дугаар тогтоолоор “МТЗ” ТӨХК-ийн балансад шилжин ирсэн. Шилжүүлэн ачих цогцолбор / цаашид ШАЦ гэх/ нь Хятадын төмөр зам /цаашид ХТЗ гэх/-с нарийн царигаар вагон болон чингэлэг илгээлтээр тээвэрлэгдэн ирж байгаа ачааг өргөн царигийн дотоод болон гадаад паркийн вагонуудад шилжүүлэн ачих, талбай болон агуулахад буулгаж хадгалах, хүлээн авагчид нь олгох, БНХАУ-аас автомашинаар тээвэрлэгдэн ирж буй импортын ачаа /чингэлэг гэх мэт/-г вагонд ачих, экспортод гарч буй ачаа /чингэлэг гэх мэт/-г вагон болон автомашинд шилжүүлэн ачих, орон нутгийн харилцаанд тээвэрлэгдэж буй ачааг тээвэрт хүлээн авч ачих, буулгах, олгох, ачааны дагалдах тээврийн бичиг баримтыг бүрдүүлэх, тооцоо хийх, тайлан гаргах үйл ажиллагааг гүйцэтгэдэг.

### ШАЦ-ын ачилт буулгалтын талбайн мэдээлэл

Д/д	Талбайн нэр	Урт/м/	Өргөн /м/	Өндөр /м/	Талбайн хэмжээ /м²/
<b>2-р талбай</b>					<b>51240м² /51,2га/</b>
	Чингэлгийн талбай	350	36	-	12600м², 40 футын 288 чингэлэг
	Ялгалтын өндөрлөсөн тавцан	120	15	1.2	1800м²
	Задгай саравчтай агуулах	30	10	-	300
	Нурмаг ачаа буулгах талбай	36	6	-	216
<b>Тавцангийн нийт талбай</b>					<b>14916</b>
<b>Хашааны нийт урт</b>					<b>1122м</b>

### ШАЦ-ын Замуудын тодорхойлолт

Д/д	Замын дугаар	Замын бүрэн урт /м/	Багтаамж /вагон тооцоот урт 14м/	Ашигтай урт /м/	Ачилтын фронт м, вагон/	Хэвгий %
1	Өргөн царигийн 3-р зам	667м	38 вагон	543м	350м 24 вагон	-0,017
2	Нарийн царигийн 7-р зам	975,7м	44 вагон	672,5м	350м 24 вагон	+0,057
3	Өргөн царигийн 4-р зам	607м	38 вагон	533м	350м 24 вагон	-0,1255
4	Өргөн царигийн 8-р зам	678м	43 вагон	613м	350м 24 вагон	-01594
5	Нарийн царигийн 8-р зам	666м	43 вагон	607,6м	350м 24 вагон	+0,017

Төрийн өмчийн хорооноос улсын төсөвт оруулах орлогын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дээрх ШАЦ-1-ийг 2008 онд “Монголын төмөр зам” ТӨХК байгуулагдах үед балансаас балансад шууд



шилжүүлж өгсөн боловч гэрээний хугацаа дуусаагүй шалтгаанаар УБТЗ ХНН уг цогцолборыг 2015 он хүртэл ашигласан.

Гэрээний хугацаа нэгэнт дууссан тул Зам, тээврийн сайд, Төрийн өмчийн хорооны даргын хамтарсан 2015 оны 29/Б/24, Зам, тээврийн сайдын 106 болон Төрийн өмчийн хорооны даргын А/94 тоот тушаалуудаар Шилжүүлэн ачих цогцолбор байгууламжийн өмч хөрөнгийг “Монголын төмөр зам” ТӨХК 2015 оны 4 дүгээр сарын 24-нд актаар хүлээн авсан.

2016 оны 03.10-нд УБТЗ ХНН-тай ТГ/16/002, ТГ201626/02, №87 тоот “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ”-г байгуулан ажиллаж байсан. УБТЗ ХНН нь 2020.03.06-ны өдрийн 10/575 тоот албан бичгээр уг гэрээг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөр дуусгавар болгож буй талаар мэдэгдсэн. ТӨБЗГ-ын даргын тушаал, ЗГ-ын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4-т заасныг үндэслэн “Монголын төмөр зам” ТӨХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн хооронд үүссэн төрийн өмчийн түрээсийн гэрээ түүнтэй холбоотой асуудлыг хянан шалгах холбогдох санал дүгнэлт гаргах, гаргасан дүгнэлтээ ТӨБЗГ-ын хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу ажиллан ашиглах боломжгүй болон өөр өмчлөлд шилжсэн нийт 11 төрлийн 16 ширхэг эд хөрөнгийг түрээсийн зүйлийн жагсаалтаас хасаж, ТГ/20/638, ТүГ-20/265-262/16 тоот гэрээг 2020 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс 4 жилийн хугацаатай байгуулан ажиллаж байна. Мөн өмнөх түрээсийн гэрээ дуусгавар болсноос шинээр гэрээ байгуулах хүртэлх хугацааны төлбөрийн 40%-ийг тооцож авахаар болсон.

### 8.3 Замын-Үүд Логистик төвийн үйл ажиллагааны талаар

- Замын-Үүд Логистикийн төв нь өргөн болон нарийн царигийн 11,6 км орчим төмөр зам, түвшинд огтлолцох хүнд даацын төмөр бетон гүүрэн байгууламж, 1,6 км авто зам, дэд бүтэц, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, нарийн болон өргөн царигийн ачилт буулгалтын 4 замтай, шилжүүлэн ачилт хийх зориулалттай 50 тн даацтай 2 вандан крантай нийт 128 га талбайг хамарсан шилжүүлэн ачилт болон логистикийн үйлчилгээ үзүүлэх цогц байгууламж юм.

#### Замын-Үүд логистик төвийн өнөөгийн байдал, хийгдэж буй ажлууд

- 2020 оны 01 дүгээр сарын 25-28-ны өдрүүдэд “МТЗ” ТӨХК-ийн болон УБТЗ “ХНН”-ийн төлөөлөл хамтран Замын-Үүд Логистик төвд ажиллаж, 2019 оны 7-р сарын 23-ны өдөр байгуулсан “ТГ/19/373” тоот “Төрийн өөрийн өмчийг түрээслэх гэрээ”-ний хавсралт №2 буюу 107,771,061,197.35 /нэг зуун долоон тэрбум долоон зуун далан нэгэн сая, жаран нэгэн мянга нэг зуун ерэн долоон төгрөг гучин таван мөнгө/ төгрөгийн Түрээсийн хөрөнгө хүлээлцэх актыг үйлдэв.
- МТЗ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/14 тоот тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг нь батлагдсан удирдамжийн хүрээнд “Бүс нутгийн Логистикийн төвийн ТГ/19/373 дугаартай түрээсийн гэрээний 2.1-т заасны дагуу УБТЗ ХНН-тэй хамтран гаргасан “Түрээсийн гэрээний хөрөнгө хүлээлцсэн акт”-д тусгагдсаны дагуу Логистикийн төвд түрээслэгч талаас хийх ажлын төлөвлөгөө”-ний дагуу ажлуудаа хийж гүйцэтгэсэн. Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 20 ажлаас доорх ажлууд 2021 онд хийгдэж байна. Үүнд:
  - №2, №3 дугаар ажил – Газар өмчлөх улсын бүртгэлийн гэрчилгээ гараагүй тул хүлээгдэж байна.
  - №8–ДТХ ба дохиолол холбооны байгууламжийн нөөц бүрдүүлэлт хийх ажил нь компанийн 2021 оны эдийн засгийн зорилтот түвшинд оруулахаар танилцуулгаар оруулсан боловч дэмжигдээгүй тул 2021 оны тодотголоор оруулахаар төлөвлөж байна.
  - №12-Программ хангамж солих төлбөр болох 35010 ам долларыг компанийн 2021 оны эдийн засгийн зорилтот түвшинд оруулахаар танилцуулгаар оруулсан боловч дэмжигдээгүй тул 2021 оны тодотголоор оруулахаар төлөвлөж байна.
  - Замын нөөц сэлбэгийн бүрдүүлэлт хийх ажлын хувьд УБТЗ ХНН-ээс ирүүлсэн шаардлагатай сэлбэг хэрэгслийн жагсаалтаас зарим нэр төрлийг тодруулах шаардлагатай болсон тул УБТЗ ХНН-ийн ЗҮШАА-д хандан албан бичиг хүргүүлсэн. Жагссаалт тодорхой болмогц худалдан авалтын ажилтнууд тендер зарлах болно.

- Дорноговь аймгийн онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 083/49 тоот дүгнэлтээр 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх 1 жилийн хугацаанд хугацаанд үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг авсан.
- Гаалийн Ерөнхий Газрын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/104 тоот тушаалын дагуу Замын-Үүд дэх гаалийн газартай байгуулсан ҮҮГ-20/177-174/54 дугаартай “Гаалийн хяналтын бүс эзэмшигчтэй байгуулах гэрээ”-ний хугацаа дуусгавар болсон тул 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр ҮҮГ-21/86-86/24 дугаартай гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулсан.
  - Замын-Үүд Логистикийн төвийн ТГ/19/373 гэрээний хэрэгжилтийг хангуулах, үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай 2 багц ажлын зардал болох 172,672.000 төгрөгийн асуудлын ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлэх материалыг бэлдсэн. Уг асуудлыг ТУЗ-ын хурлаар танилцуулж дэмжигдсэн. Энэ ажлын хүрээнд худалдан авалтын мэргэжилтнүүд 136,152,200 төгрөгөөр төсөвлөгдсөн Засварын төвийн гарашийн засварлах ажлыг тендер зарлан 126,801,526 төгрөгөөр “Бэсүб констракшн” ХХК-аар гүйцэтгүүлж, 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар “ажил хүлээлцэх акт” үйлдэх шатандаа явж байна.
  - 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр ЗТХЯ-нд болсон “Замын-Үүд Логистик төв”-ийн тухай хэлэлцсэн 6 талын оролцоотой хурлаар RMG-50t-50m маркийн 50 тоннын даацтай вандан кранд удаа дараа зөрчил, доголдол гарч, засварын ажил хийсэн боловч зөрчил арилаагүй, улмаар холбогдох байгууллагуудаар гаргуулсан дүгнэлтийг үндэслэн вандан краны замыг Хятадын төмөр замын 21-р товчоо групп ХХК засварлаж, 1 вандан краны 9 ширхэг дугуйг Хятадын төмөр замын 21-р товчоо групп ХХК, Хятадын Хэнань Дафанг Хэви Машинери компанийн зардлаар нийлүүлэх, туслан гүйцэтгэгч Цамхагт кран ХХК нь 2021 оны 04 дүгээр сард сольж угсарч өгсөн бөгөөд одоо хэвийн ажиллагаатай болсон. Кран ажиллаагүй хугацааны түрээсийг зардлыг тооцон УБТЗ ХНН-ийн төлөх түрээсийн зардлаас хасаж тооцсон.
- Замын-Үүд Логистикийн төвийн ТГ/19/373 гэрээний хэрэгжилтийг хангуулах, үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай 4 багц ажлын зардал болох 299,891,444 төгрөгийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар чиглэл авах хүсэлтээ 2020.10.29-ны өдрийн 01/1360 тоот албан бичгээр ТӨБЗГ-ын дарга Б.Цэнгэлд хүргүүлж, 2020.12.08-ны өдрийн А-1/2136 албан бичгээр 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган, түрээсийн төлбөрөөс суутган тооцоход татгалзах зүйлгүй гэсэн хариуг авсан. Шаардлагатай 4 багц ажлыг 2021 оны эдийн засгийн зорилтот түвшинд ороогүй тул тодотголоор оруулахаар төлөвлөж байна.
- 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдөр УБТЗ ХНН-тай 19/373 дугаартай “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ”-г байгуулан, 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр гэрээний 2 дахь хавсралт болох “Замын-Үүдийн Логистикийн төвийн хөрөнгө хүлээлцэх акт”-ыг талууд үйлдсэнээр гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдөр цахимаар гэрээ дүгнэх хурал хийсэн ч гаалийн түр агуулахын бохирын шугамын бөглөрөл болон бусад асуудлаар газар дээр нь комисс очиж ажиласны дараа дахин үргэлжлүүлэн хуралдахаар тохиролцов.

## 9 . ТЯНЬЖИН ТЭЭВЭР ЛОЖИСТИК ТӨВ ТӨСӨЛ

### 9.1 Төслийн хураангуй

БНХАУ-ын Тяньжин хотын Ардын засаг захиргаа, Монгол Улсын Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамтай /хуучнаар/ хамтран 2009 онд Тяньжин хотын Бинхай шинэ дүүрэгт хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх тухай санамж бичиг, Монгол Улсын Засгийн газрын “Далайд гарах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2013 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 152 дугаар тогтоолын хүрээнд Дунзян чөлөөт худалдааны боомт бүсийн 10 га газарт 50 жилийн хугацаатай “Тээвэр-ложистикийн төв” байгуулахаар шийдвэрлэсэн. Хятадын талаас “Тяньжин порт эдийн засаг, технологийн хамтын ажиллагаа” ХХК 51 хувийг, Монголын талаас “Монголын төмөр зам” ТӨХК 49 хувийг эзэмших юм.

Төсөл хэрэгжиж эхэлснээр Тяньжин боомтоор дамжин өнгөрөх Монгол Улсын импорт, экспортын бараа бүтээгдэхүүнийг хадгалах, задгай талбайн үйлчилгээ үзүүлэх, чөлөөт бүсийн

орчинд бараа бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүнийг стандарт агуулахад хадгалах, талбай түрээслэх, тээвэр зууч, ложистикийн үйлчилгээг үзүүлэх юм.

## 9.2 Төслийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын асуудал

Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03 дугаар тушаалаар Тяньжин төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилго бүхий ЗТХ-ийн дэд сайдаар ахлуулсан ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан бөгөөд хавсралтаар ажлын хэсгийн удирдамж, хувийн хэвшлийг сонгон шалгаруулах журам батлагдсан. Тус ажлын хэсэг нь 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хуралдсан бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр “Юань Жин Монгол” ХХК-иас ирүүлсэн гэрээний хугацааг сунгах хүсэлтийг хүлээн авах боломжгүй шийдвэр гаргасан бөгөөд шийдвэрийг “Юань Жин Монгол” ХХК-д албан бичгээр хүргүүлсэн. Ажлын хэсэг нь цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний графикчилсан төлөвлөгөөг боловсруулсан.

2018 оны 01 дүгээр сарын 29-нөөс 02 дугаар сарын 02-ны өдрүүдэд ЗТХ-ийн сайд Ж.Бат-Эрдэнэ тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-д айлчлах үеэр Тяньжин хотын Ардын Засгийн газар, Дунзян чөлөөт худалдааны боомт бүсийн удирдлагуудтай уулзан, төсөл хэрэгжүүлэх газрын өнөөгийн байдал, орчинтой танилцсан бөгөөд санамж бичгийг 2018 оны 04 дүгээр сард Ерөнхий сайдын БНХАУ-д хийх айлчлалын үеэр байгуулахаар тохиролцсон. Санамж бичгийн төсөлд Ажлын хэсгийн гишүүдээс саналыг авч, ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын мэргэжилтэн А.Анарт цахимаар хүргүүлсэн.

Санамж бичигт оруулах саналаа Хятадын талаас 2018 оны 03 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн бөгөөд 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Монголын талаас ТЗДТБХЗГ, Хятадын талаас Гадаад харилцааны газрын төлөөлөл санамж бичгийн төслийг үзэглэсэн.

2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн Зам, тээврийн хөгжлийн Дэд сайдаар ахлуулсан Ажлын хэсгийн хоёрдугаар хуралдаанаар урилга зарлах хугацаа, хувийн хэвшлүүдэд хүргүүлэх материал, хамтарч ажиллах хэлбэрийн талаар тус тус хэлэлцсэн.

БНХАУ-ын Тяньжин хотын Ардын Засгийн газар болон Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яамны хооронд 2009 онд байгуулсан санамж бичгийг албан шугамаар шинэчлэн байгуулсны дараа төсөлд хөрөнгө оруулж, “МТЗ” ТӨХК-тай хамтран ажиллах хувийн хэвшлийг сонгон шалгаруулах тухай урилгыг хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтлүүлэхээр төлөвлөсөн. Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг нь төсөлд оролцох хүсэлтээ илэрхийлэн, шаардлагатай бичиг, баримтуудыг ирүүлсэн хувийн хэвшлийн материалд батлагдсан журмын дагуу үнэлгээ өгч, сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. Сонирхсон хувийн хэвшилд хүргүүлэх төслийн танилцуулга, холбогдох мэдээлэл, хамтран ажиллах хэлбэр буюу Төслийн зориулалттай компани /ТЗК/ байгуулж ажиллах тухай, ТЗК байгуулах дарааллын талаарх мэдээллийг тус тус Ажлын хэсгээр хэлэлцүүлсэн. Одоогоор, төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхол бүхий хувийн хэвшлүүдийн төлөөлөл “Монголын төмөр зам” ТӨХК-ийн байранд ирж, уулзалт зохион байгуулж, холбогдох мэдээллийг авч байна.

## 10. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ГАЗАР

### 10. Хяналт шалгалтын газар.

Хяналт, шалгалтын газар нь Гүйцэтгэх захирлын нь 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/25 тоот тушаалаар “Монголын төмөр зам” ТӨХК-ийн “Хяналт, шалгалтын дүрэм”-ээ батлуулснаар:

- Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
- Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэнгүүд
- Хөдөлгөөн, ачаа тээвэр хариуцсан байцаагч
- Хөдлөх бүрэлдэхүүн хариуцсан байцаагч
- Зам хариуцсан байцаагч
- Дохиолол холбоо хариуцсан байцаагч
- Байгаль орчин хариуцсан мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэйгээр үндсэн үйл ажиллагаагаа дүрэм, журмын хүрээнд явуулж байна.

Хяналт шалгалтын газар нь 2021 оны байдлаар:

- ХШГ-ын жилийн болон сар бүрийн ажлын төлөвлөгөө, Сайдын 01 албан даалгаврын дагуу хийх ажлын төлөвлөгөө, Тавантолгой-Зүүнбаян төмөр замд ажилласан, Төмөртэй өртөөнд ажилласан талаарх ажлын төлөвлөгөө, үер усны чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө зэрэг нийт 11 удаагийн ажлын төлөвлөлт, төлөвлөгөө гарган гүйцэтгэлийг хангаж ажилласан.

- Эхний хагас жилийн байдлаар “Цар тахлын гамшгаас хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам” “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл дээр эмч ажиллуулах, үзлэг хийх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам” “Компанитай үйлчилгээ үзүүлэх гэрээтэй автомашин ашиглах журам”, “Техникийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалт авах журам”, “Ковид-19 халдварт өвчний үед ажлын байрны халдвар хамгааллын дэглэмийг хэрхэн мөрдөж ажиллах түр журам” нийт 5 журмыг боловсруулан батлуулж мөрдүүлэн ажиллаж байна.

-Тавантолгой-Зүүнбаян төмөр замын трассын дагуу 1 удаа, Төмөртэй төмөр замд 1 удаагийн хяналт шалгалтыг ХШГ-ын бүрэн бүрэлдэхүүнтэй хийж ГТХАБ-ыг хэрхэн хангаж буйд хяналт тавьж ажилласан.

## **1. Ажлын төлөвлөлт, биелэлтийн чиглэлээр:**

ХШГ-аас 2021 онд хийж хэрэгжүүлэх 61 заалттай нэгдсэн ажлын төлөвлөгөө гарган батлуулан гүйцэтгэлийг цаг тухай бүрд нь хэрэгжүүлж ажиллаж байна.

ХШГ-ын жилийн ажлын нэгдсэн төлөвлөгөөний биелэлт эхний хагас жилийн байдлаар 45 хувьтай байна. Цар тахалтай /Covid-19/ холбоотойгоор 28 хувьтай тай байгаа биелэгдээгүй ажлуудыг үлдсэн хугацаанд гүйцээж хийхээр төлөвлөн ажиллаж байна.

ХШГ-ын ажилтнуудын тухайн сард хийж хэрэгжүүлэх хувийн ажлын төлөвлөгөөг нэгтгэн гаргаж гүйцэтгэлийг сар бүр дүгнэж ажиллаж байна.

Цар тахалтай /Covid-19/ холбоотойгоор сарын ажлын төлөвлөгөөний биелэлтүүд тодорхой хувиар тасарсан үзүүлэлтэй гарч байна.

## **2. Удирдлагаас өгөгдсөн үүрэг, даалгаврын чиглэлээр:**

Зам, тээврийн хөгжлийн сайдын 01 албан даалгаврын дагуу компанийн хэмжээнд хийж хэрэгжүүлэх 20 заалттай ажлын төлөвлөгөө гарган гүйцэтгэлийг хангуулан ажиллаж байна

01 албан даалгаврын заалт бүрээр биелэлтийг гарган сар бүрийн 25-ны өдөр ЗТХЯ-ны холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 01 албан даалгаврын 1.9 дахь заалтын дагуу “Замыг үер усны аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх” талаар компанийн хэмжээнд хийж хэрэгжүүлэх 30 заалттай нэгдсэн төлөвлөгөө гарган дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Төмөртэй төмөр замд хаврын шар усны үерээс сэргийлж, гүүр хоолойн оролт гаралтын хог шороог цэвэрлэн ус чөлөөтэй нэвтрүүлэх ажлыг 32 ш гүүр хоолойн дээр хийснээр усыг чөлөөтэй нэвтрүүлэх арга хэмжээг авч ажилласан. Тавантолгой-Зүүнбаян төмөр замын трассын дагуух гүүр хоолой, хиймэл төхөөрөмж, суваг, шуудууны байдлыг Зам хариуцсан байцаагч, Замын ангийн дарга нар SPZ-200W балласт тохируулагч машинаар тууш явж шалгасан. Үер усны үед хэрхэн ажиллах талаар нийт замчдад ээлжит бус давтан зааварчилгааг өгч танилцуулсан ба тушаалаар үер усны эргүүлээр 2 замчин томилж, батлагдсан графикайн дагуу үер усны эргүүлийг тогтмол хийж ажиллаж байна. Замын мастер, бригадын дарга нар үер усны мэдээ мэдээллийг тухай бүрд нь холбогдох албан тушаалтнуудад шуурхай мэдээллэж ажиллаж байгаа ба нийт 18 удаагийн мэдээ, мэдээллийг дамжуулж ажилласан. Цаг агаартай холбогдолтой дотоод гадаадын интернет сайтуудыг хэрхэн ашиглах талаар холбогдох ажилтнуудад заавар зөвлөгөөг өгсөн. Үер усны үед анхаарамж олгогдох км-үүдийн жагсаалтыг шинэчилж, аялалд явж байгаа 2 илчит тэрэгний 4 кабинд байнгын байдлаар машинч нарт танилцуулж, анхаарамжийн бланкан дээр бичиж байрлуулсан.

"ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР"-тай үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулан цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг замын урд болон хойд чиглэлээр цаг тухай бүрд нь авч холбогдох албан тушаалтнуудад шуурхай дамжуулах арга хэмжээг авч ажиллаж байна.

Улсын онцгой комиссын 2021-05-25-ны өдрийн №05 дугаартай албан даалгаврын холбогдох заалтуудын дагуу компанийн хэмжээнд нийт ажилтнуудад амралт зугаалгын үеэр үер усны аюулаас урьдчилан сэргийлэх талаар ээлжит бус давтан зааварчилгааг өгч танилцуулсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/211 тоот тушаалын дагуу “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төмөртэй өртөөний төмөр замын тээвэрлэлт нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхэд ЗТХЯ, “МТЗ” ТӨХК, “УБТЗ” ХНН-ийн хамтарсан комиссын бүрэлдэхүүн хяналт шалгалт хийсэн ба илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгах талаарх Зам, тээврийн хөгжлийн яамны 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 38-07-074/094 тоот дугаартай улсын байцаагчийн албан шаардлагын мөрөөр хийж хэрэгжүүлэх 45 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан. Албан шаардлагын хариуг заасан хугацаанд нь буюу 2021 оны 2-р сарын 26-нд хийсэн ажлын талаарх тайлан, биелэлтийн хамт албан бичгээр хариуг хүргүүлсэн.

### **3. Тавантолгой-Зүүнбаян төмөр замын төсөл дээр ажилласан талаар:**

2021 оны 5 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд ХШГ-ын дарга, байцаагч нарын бүрэлдэхүүнтэй комисс пк 0 цэгээс пк 129 хоорондох замын дээд бүтцийн ажлын явц, балласт ачилт буулгалтын ажлын явц, Цэций өртөө, пк 60-р зөрлөгийн зам сумын угсралтын ажлын гүйцэтгэл, ажилчдын ажил үүрэг гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны байдалд хяналт шалгалт хийж холбогдох шаардлагуудыг тавьж цаашид хэрхэн ажиллах талаарх заавар зөвлөгөөг өгч ажилласан.

- Цэций өртөөний зам сумын угсралтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахад:

Өртөөний замуудын хооронд 0,5 мм шебурь асгаж сэлгээний ажил үүрэг гүйцэтгэх ажилтнуудын аюулгүй байдлыг хангах шаардлагатай.

Өртөөний замуудын уулзварын дутуу боолтуудыг гүйцээж хийх.

Угсарсан суман шилжүүлгүүд суулт, чигтэй, боолтууд дутуу боогдсон зэргийг засаж хэвийн болгох талаар “УБТЗ” ХНН-ийн ажил удирдагчид чиглэл үүрэг өгч ажилласан.

-Пк 60 зөрлөгийн зам сумын байдалд үзлэг, шалгалт хийхэд:

Зөрлөгийн замуудын уулзварын боолтууд дутуу

2-р замын балласт дутуу буусан

Зөрлөг дээрх сэлгээний ажил үүрэг гүйцэтгэх ажилчдын ажил үүргийн хуваарилалт тодорхой бус байгааг анхаарч копаниас гаргаж өгсөн түр журмыг баримтлан ажиллах талаар чиглэл үүрэг өгсөн.

Трассын дагуух гүүр хоолой, хиймэл төхөөрөмж, суваг, шуудууны байдлыг Зам засварын ангийн даргатай хамт SPZ-200W балласт тохируулагч машинаар тууш явж шалгасан. Шалгалтаар жижиг хэмжээтэй инхэнх усны хоолойнууд элсэнд дарагдсан, хоорондын замын пк3,17,42,44,68,70,74 зарим хэсэгтээ элс зам давж шуурсан байдалтай байсныг ЗХЖШ-ийн ангиудын цэргүүдээр пк 42,44-ын замын элсийг гараар гаргах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. Зам засварын ангийн даргад балласт буулгалтыг түргэвчлэх мөн төсөл дээр ажиллаж буй замчдын ажил үүргийн хуваарилалтыг оновчтой зөв зохион байгуулалттайгаар ажиллуулах талаар чиглэл үүрэг өгсөн.

### **4.Төмөртэй төмөр замд ажилласан талаар:**

6 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд ХШГ-ын дарга, байцаагч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Төмөртэй өртөөний зам сумын техникийн байдалд ээлжит улирлын үзлэг шалгалтыг хийсэн. Үзлэгээр:

Урьд үзсэн үзлэг шалгалтуудын гүйцэтгэлийг шалгахад бүрэн биелүүлсэн байсан ба ээлжит үзлэгээр зам, суман дээр 10 гэмтэл, өртөөний техникийн бичиг баримт хөтлөлтийн чиглэлээр 8 зөрчил, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр 7 зөрчил, байгаль орчны чиглэлээр 5 асуудал, эрүүл ахуйн чиглэлээр 8 зөрчил нийт 38 гэмтэл, зөрчил, дутагдлыг илрүүлсэн.

Үзлэгийн дүнгийн хурлыг Төмөртэй өртөөний нийт ажилчдын дунд зохион байгуулан хурлын тэмдэглэл хөтөлсөн. Үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлуудыг холбогдох албан тушаалтан бүр дээр авч хэлэлцэн гэмтэл зөрчлийг засаж арилгах хугацаатай үүрэг өгч цаашид давтан гаргахгүй байх тал дээр мэргэжлийн арга зүйн зөвлөмжийг өгсөн.

Төмөртэй өртөөнд хийсэн ээлжит үзлэгийн мөрөөр хийж хэрэгжүүлэх 21 заалттай төлөвлөгөө гарган гүйцэтгэлийг хангуулах чиглэлээр хяналт тавьж ажиллаж байна.

Ээлжит үзлэгээр илэрсэн гэмтэл зөрчлүүдийг засаж арилгах талаарх ХШГ-ын 01 албан шаардлагыг Төмөртэй өртөөний удирдлагуудад хүргүүлсэн ба Төмөртэй өртөөний зүгээс шаардлагын мөрөөр хийж хэрэгжүүлэх 46 заалттай төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж ажиллаж байна.

Гүйцэтгэх захирлын А/10, А/22 тоот тушаалуудаар Төмөртэй өртөөний дохиолол, холбооны байгууламж, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт хийж, илэрсэн доголдол, дутагдлыг арилгаж, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй, найдвартай, хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна.

Замын-Үүд дэх Бүс нутгийн логистик төвийн ДТХ байгууламжийн систем гэмтэлтэй байсныг БНХАУ-ын 21-р товчооны мэргэжилтэн, орчуулагч нартай очиж шаардагдах төхөөрөмжийг сольж ажиллагааг шалган акт бүрдүүлж Дохиолол холбооны III ангийн ерөнхий инженерт хүлээлгэж өгсөн.

Төмөртэй өртөөний дохиоллын байгууламжийн тасралтгүй тэжээлийн үүсгүүр (UPS)-н 32 ширхэг зай хураагуурыг шинээр сольсон.

Төмөртэй өртөөний ДТХ-н байгууламжийн төвийн үндсэн А нөөц В процессорын тасралтгүй тэжээлийн үүсгүүр (UPS)-н 8 ширхэг зай хураагуур шинээр сольсон.

Төмөртэй өртөөний цахилгаан шилжүүлэгчийн тогтмол гүйдлийн мотор шалгаж баталгаажуулах “Стенд”-ийн бүдүүвч, заавар, ажиллагааг техникийн зөвлөлөөр хэлэлцэж, Гүйцэтгэх захирал баталгаажуулсан.

ДТХ ба Холбооны хээрийн болон постны байгууламжийн газардуулгын эсэргүүцэл хэмжсэн шалгав.

Хээрийн байгууламж газардуулгын эсэргүүцэл 8-с-15 ом, Постны байгууламжийн газардуулгын эсэргүүцэл 1с-2 омын хооронд хэмжигдэж байна. Төмөртэй өртөөний ДТХ ба холбооны хээрийн болон постны байгууламжийн газардуулга хэмжсэн.

ДТХ-н байгууламжийн найдвартай ажиллагааг ханган ажиллах зорилгоор дохионы шатсан диодыг ширхэглэн сольж нөөцийг тогтмол бүрдүүлдэг.

ЗТХ-ний тусгаарлах уулзварын дугаар, хээрийн байгууламжийн хаяг шинэчилсэн.

дтх ба холбооны байгууламжын газардуулгын хэмжих судалгаа хийж заавар боловсруулан

UT521 DIGITAL EARTH TESTER багажны тухай гарын авлага боловсруулсан.

Төмөртэй өртөөний зам сумын техникийн байдлыг дээшлүүлэх чиглэлээр 2 тн хадаасны хангалтыг хийлгэж, нийт 30 суман шилжүүлгийн хадаасыг нэмж хадан, хүчжүүлэх ажлыг зохион байгуулж хийсэн.

Мөн суман шилжүүлгүүдийн царигийг тохируулж хадах болон өргөж чигжилт хийх ажлуудын график гарган нийт 17 суман шилжүүлэг дээр цариг тохируулах, өргөлт чигжилтийн ажлыг хийж гүйцэтгэн галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

2 ширхэг тоонолж хангалтаар ирснээс элэгдэл, хорогдол нь норм, хэмжээнээс хэтэрсэн 1 ширхэг тоонолжийг сольж аюулгүй байдлыг хангасан ба үлдсэн 1 ширхэг тоонолжийг нөөцөнд тавьсан.

Тоонолж, шорын элэгдлийн эрчимжилтийг бууруулах зорилгоор шамралт, сөртөсүүдийг тогтмол авч тосолгоо үйлчилгээг байнга хийж байх чиглэлээр замын мастер, бригадын дарга нарт шаардлага тавьж ажиллаж байна.

Хандгайт-Төмөртэй хоорондын замын 21-р км-ийн гарманд үзлэг хийж гармын шалавч дүнг хагарч муудсан байсныг шинээр солиулах арга хэмжээг авч ажилласан ба гармын ойролцоох малын хориг хашааг хүчжүүлэн засварлуулсан. Хоорондын замын СЗ маягийн бэхэлгээний даруулга боолтуудыг



тослох ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн ба тосолгоонд шаардлагатай ажилласан масолыг депогоос авах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан.

Төмөртэй төмөр замын Зам хэмжигч вагоны лентенд дүн шинжилгээ хийж замын гэмтлийн талаарх судалгааг гарган цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар чиглэл үүрэг өгч ажиллаж байна.

6 дугаар сард ээлжит улирлын үзлэгээр Төмөртэй өртөөний зам сумын техникийн байдалд үзлэг шалгалт хийж урьд үзсэн үзлэг шалгалтуудын гүйцэтгэлийг шалгасан ба шалгалтаар нийт 6 гэмтэл, зөрчил илэрснийг хугацаатай засах үүрэг даалгавар өгч ажилласан.

Төмөртэй өртөөний болон хоорондын замын техникийн байдлын хаврын техникийн паспортын үзлэгийн материалд дүн шинжилгээ хийж үзлэгийн мөрөөр үүрэг даалгавар өгсөн ба замд тэнцэхгүй 1 ком дүнзийг солиулах ажлыг зохион байгуулж хийлгэсэн.

5 дугаар сард Төмөртэй өртөөний Замын хэсгийн хатуу тооцоот багажинд хагас жилийн тооллого хийж бүртгэлтэй багажуудыг тулгалт хийж шалгахад хатуу тооцоот багажууд бүрэн байсан ба арчилгаа, үйлчилгээтэй холбоотой 2 зөрчил гарсныг хугацаатай засах үүрэг өгч акт үйлдсэн.

Хөдөлгөөн, ачаа тээврийн чиглэлээр:

- Өртөөний дарга орлогч дарга, зааварлагч машинч нар 2021 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг газрын дарга гүйцэтгэх захирлаар батлуулаагүй байсан.

- Өртөөний техник захирамжийн акт, технологийн процессийг боловсруулсан, хянасан, танилцсан зэрэг гарын үсэг байхгүй ажилчдад он эхлээд сургалт явуулж танилцуулаагүй байна.

- Зам сумын сарын үзлэгийг цаг тухай бүр нь тогтмол хийж байх. Хугацаа хоцроож байна.

- Хөдөлгөөн ачаа тээврийн бичиг баримтуудыг тогтмол шалгадаггүй, бичиг баримтын үзлэг шалгалт хангалтгүй.

- Хагас автомат хориглолын гэмтэлтэй үеийн ажиллагааны талаар өртөөний жижүүрүүдэд сургалт явуулах.

- Гүйцэтгэх захирлын А-10 тоот тушаалын дагуу цаасан норматив хөтлөлт хангалтгүй байна.

- Өртөөний даргын зүгээс ачаа тээврийн бичиг баримтанд тавих хяналт, гүйцэтгэл хангалтгүй, ажилтнуудын гарын үсэг дутуу, ажил хүлээлцэх үйл ажиллагааг сайжруулах. хөдөлгөөний жижүүрийн бичиг баримт дээр ганц нэг зөрчилтэй.

- 2021 оны 5 сарын 24-нд 210997 дугаартай вагонд зөөврийн 2 ширхэг сууц буусан ч буулгалтын дэвтэрт тэмдэглэж хүлээн авагч пүүлэгч гарын үсэг зураагүй 2021 оны 6 дугаар сарын 04-нд найруулагч Л.Лувсанбат ажлаас буухдаа хатуу тооцоот багажийн дэвтэрт 16 номерийн эвүүрийг давхардуулан бичсэн зэрэг зөрчлүүдийг илрүүлж үүрэг чиглэл өгсөн.

Зам сумаар, зам паркаар ажиллахад хатуу тооцоот багаж, эвүүрийн хадгалалт хамгаалалт, ашиглалт хэвийн, даруулсан, бэхлэсэн байдал хэвийн.

ТЧМ бригадуудын ажлын байраар явж үзлэг хийхэд, ажлын байранд тамхи их татаж байна, тамхины ишийг ил задгай хаяж байна, галын аюулгүй байдлыг хангаж ажиллах шаардлагатай байгааг газар дээр нь үүрэг өгсөн. ТЧМ-ийн зааварлагч машинч Ч.Жадамбаа нь сэлбэг материал, засвар үйлчилгээ, тосолгооны материалуудыг гадагш, өөр шугам замд явуулахад мөнгө санхүүгийн байдлыг түргэн шуурхай шийдвэрлэх талаар санал хүсэлтийг хүлээн авч СЭЗГ-т шаардлага тавьсан.

Өртөөн дээрх сэлгээний ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийхэд сэлгээний ажлын бригад ажил үүргээ дүрэм, журмын дагуу хэвийн гүйцэтгэж байв.

## **5. Байгаль орчны чиглэлээр:**

Хяналт, шалгалтын газрын 2021 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төслийн талбай болон Төмөртэй өртөөн дээр ажиллах, үзлэг, шалгалт хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хангуулах, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэх чиглэлээр ажиллалаа.

Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл:

Үзлэг, шалгалт. Зэвсэгт хүчний барилга-инженерийн цэргийн удирдах газартай байгуулсан “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-ний явцын дүгнэлтийг хийх ажлаар 03 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд төслийн талбай дээр ажилласан. Талбайд ажиллах явцад дараах нөхцөл байдал илэрсэн болно. Үүнд:

- Трасс дагуу хаягдал шороо буулгасан.
- Далан болон технологийн зам дагуу хог хаягдал их.
- Технологийн замын гадуур салаа замууд гарсан.
- Нөхөн сэргээлт хийсэн карьерт ахуйн хог хаягдал хаясан.
- Кемп, узель, шатахуун түгээх цэгүүд байрлаж байсан газруудад талбайн цэвэрлэгээ бүрэн хийгдээгүй.
- Зарим карьерын түр зам хэт зузаан буюу нөхөн сэргээлт хийлгүй зам тавьсан.
- Хоолой орчимд талбайн цэвэрлэгээ, жигдрүүлэлт бүрэн хийгдээгүй.
- Зүүнбаян хэсэгт далангийн орц, газрыг ойр ойрхон, олон цэгт үлдээсэн.
- Нөхөн сэргээлт хийсэн газруудад дахин ашиглалт явуулсан, хаягдал шороо, цемент асгасан
- Дорноговь аймгийн хэмжээнд нөхөн сэргээлт хүлээлгэж өгөх ажил бүрэн дуусаагүй.

Иймд үзлэгийн мөрөөр цаашид засаж сайжруулах ажлын чиглэл, жагсаалтыг гарган гэрээний дүгнэлтэд тусгалаа. Үүнээс трассын дагуух ахуйн болон технологийн хог хаягдлыг цэвэрлэх, талбайн цэвэрлэгээ, жигдрүүлэлтийг хийж улсын комисс ажиллах нөхцөлд бэлэн байлгах нь хамгийн чухал байна.

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө:**

Төслийн 2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулж 2021 оны 01/599 дугаар албан бичгээр Өмнөговь, Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлсэн. Улмаар 2021 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэхэд бэлэн болоод байна.

Өмнөговь ба Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн дүгнэлтийг ирүүлээгүй улмаас 2021 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдах ажил хүлээгдэж, багагүй хугацаа өнгөрөөд байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг тогтоох, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардлагатай хөрөнгө зардлыг төлөвлөх ба үүнээс гадна байгаль орчны талаас төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн зөвшөөрөл болдог чухал ач холбогдолтой баримт бичиг юм.

**Нөхөн сэргээлт:**

Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд газар шорооны, гүүрийн барилга угсралт, балласт үйлдвэрлэх зориулалтаар нийт 199 байршилд карьер ашигласнаас 167 карьерийг орон нутагт актаар хүлээлгэж өгөөд байна. Үүнээс 167 нь газар шорооны ажилд, 12 нь гүүр, 5 нь балласт үйлдвэрлэлд ашиглагдаж байна.

Карьер ашиглалт, нөхөн сэргээлтийн ажлыг явцыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Д/д	Байршил	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зориулалт					
		Газар шороо (далан)		Гүүр		Балласт	
		Ашигласан	Хүлээлгэж өгсөн	Ашигласан	Хүлээлгэж өгсөн	Ашигласан	Хүлээлгэж өгсөн
1	Өмнөговь	86	86	-	-	3	-
2	Дорноговь	96	81	12	-	2	-
Нийт		182	167	12	-	5	-
Хувь, %		91.75		-		-	
Тайлбар		Нөхөн сэргээлтийг хийж дууссан. Аймгийн ажлын хэсэгт шалгуулах ажил хүлээгдэж байна.		Нөхөн сэргээлтийг хийж дууссан. Аймгийн ажлын хэсэгт шалгуулах ажил хүлээгдэж байна.		Нөхөн сэргээлт хийгдэж эхлээгүй байгаа.	

Тайлбар:



Нөхөн сэргээлтийг хийж дууссан. Аймгийн ажлын хэсэгт шалгуулах ажил хүлээгдэж байна. Нөхөн сэргээлтийг хийж дууссан. Аймгийн ажлын хэсэгт шалгуулах ажил хүлээгдэж байна. Нөхөн сэргээлт хийгдэж эхлээгүй байгаа.

Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын зурвас газар:

“Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Засгийн газрын 2020 оны 170 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын зурвас газрыг гэрчилгээжүүлж, газар эзэмших/ашиглах гэрээг байгуулахаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 2021 оны 01/45 дугаар албан бичгээр хандсан болно. Одоогийн байдлаар газрын гэрээг баталгаажуулах ажил орон нутгийн түвшинд явагдаж байна.

Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын цахилгаан дамжуулах агаарын шугамын зурвас газар:

Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын цахилгаан дамжуулах агаарын шугамын зурвас газрын гэрчилгээг Дорноговь аймгийн Сайншанд, Улаанбадрах сумдаас гаргуулж, гэрээг байгуулаад байна. Дорноговь аймгийн Мандах суманд хамаарах цахилгаан дамжуулах шугамын газрын асуудал 06 дугаар сарын 25-ны өдөр сумын ИТХ-аар хэлэлцэгдсэн бол Өмнөговь аймгийн Манлай, Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хамаарах газрын асуудал хариу ирээгүй, хүлээгдэж байна.

Хог хаягдлын гэрээ:

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ-тай ҮҮГ-21/81-81/21, Дорноговь аймгийн Мандах сумын ЗДТГ-тай ҮҮГ-21/82-82/22, Өмнөговь аймгийн Манлай сум Манлайнбадрах ОНӨААТҮГ ҮҮГ-21/83-83/23 дугаар бүхий хог хаягдлын гэрээг байгуулан ажиллаж байна.

Хамгаалалтын ойн зурвас байгуулах судалгаа:

Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуу элсний нүүдэл, салхи, шуурганаас хамгаалах зорилгоор хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил төлөвлөж байгаатай холбогдуулан НҮБ-ын ХХААБ-ын "Монгол орны хуурай бүс нутгаас үүдэлтэй элсэн ба шороон шуурганаас урьдчилан сэргийлэх, бууруулах" төслийн багтай холбоо тогтоож, 04 дүгээр сарын 21, 05 дугаар сарын 28-ны өдөр 2 удаа цахим уулзалт зохион байгуулсан. Цахим уулзалтаар хоёр талын хамтран ажиллах боломжийн талаар ярилцаж, урьдчилсан төлөвлөгөө гаргасан болно. Түүнлэн энэ ажлын хүрээнд “Ойн биологийн олон янз байдлын төв” НҮТББ-тай мөн холбоо тогтоож, трассын дагуу хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын нарийвчилсан судалгаа хийх үнийн саналыг аваад байна.

Төмөртэй өртөөний чиглэлээр:

Ээлжит улирлын үзлэг, хяналт, шалгалт хийх ажлаар 06 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд Төмөртэй өртөөнд ажиллав. Хяналт, шалгалтын явцад дараах нөхцөл байдлыг тогтоож, зөрчил, дутагдлыг залруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээ, Хог хаягдлын гэрээ, Ус ашиглах дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл зэрэг өртөөний оффис дээр байх шаардлагатай баримт бичгийн бүрдэл огт хангагдаагүй байна. Эдгээр баримт бичгийг зохих журмын дагуу бүрдүүлж, дотоод хяналт болон төрийн байгууллагын хяналт шалгалтад бэлэн байх нөхцөлийг бүрдүүлэх.

Хог хаягдлыг түр хадгалах цэг нь стандартын шаардлага хангаагүй, хогийн савыг зохих байршилд байршуулаагүй байна. Цаашид холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцсэн хог хаягдлын түр цэг тохижуулж, хогийн сав байршуулах.

Төмөртэй өртөөний Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ 2014 онд хийгдэж, БОАЖЯ-аар батлуулснаас хойш нэмэлт тодотгол хийгдээгүй байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу 5 жил тутамд нэмэлт тодотгол хийгдэх шаардлагатай тул БОННУ-ний нэмэлт тодотголыг хийлгэж, Байгаль орчны аудит хийлгэх.

“Журам батлах тухай” Гүйцэтгэх захирлын 2017 оны А/06 дугаар тушаалын хавсралтаар баталсан бүртгэлийн хуудсын дагуу Энгийн болон аюултай хог хаягдлын бүртгэлийг тогтмол, бүрэн хөтөлж, сар бүр ирүүлж байх.

“Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартад заасны дагуу улирал тутам ундны усны шинжилгээ хийлгэж, худгийн битүүмжлэл, хамгаалалтын бүсийг сайжруулах.

Шаардлагатай баримт бичгүүдийг бүрдлийг хангах

Компанийн эзэмшиж буй газрууд. Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс компанийн эзэмшилд байгаа газруудын судалгааг гаргасан. Одоогийн байдлаар компанийн эзэмшиж буй 9 газар байгаа ба эдгээр газруудад нэгдсэн байдлаар, холбогдох хууль тогтоомжийн дагуу газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийлгэх шаардлагатай байна. Энэхүү ажилд нийт 60,000,000.0 төгрөгийг тооцоолж байгаа ба төсвийн тодотголд оруулан батлуулахаар төлөвлөж байна.

Д/д	Байршил	Газрын хэмжээ	Эзэмших зориулалт	Нийт үнэ, төг
-----	---------	---------------	-------------------	---------------

1	Багахангай дүүрэг	30 га	Аж ахуй (Засварын төв)	60,000,000.0
2	Дорноговь, Замын-Үүд	31.18 га	Шилжүүлэн ачих талбай	
3	Дорноговь, Замын-Үүд	50 га	Холимог тээврийн ачааны терминал, ложистик төв	
4	Дорноговь, Сайншанд	43 га	Үйлдвэрийн албан контор	
5	Сэлэнгэ, Хүдэр	77.01 га	Төмөр замын зурвас газар, өртөөний барилга	
6	Сэлэнгэ, Ерөө	24.3 га	Төмөр замын зурвас газар	
7	Сэлэнгэ, Хүдэр	2 га	Ажилчдын орон сууц	
8	Сэлэнгэ, Хүдэр	1.4 га	Дэд станц	
9	Сэлэнгэ, Хүдэр	13.97 га	Шилэн кабель	

## 6. Хяналт, шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Гүйцэтгэх захирлын 2020 оны А тушаалын биелэлтэд хяналт шижилгээ хийж, үнэлгээний дүнг нэгтгэж, дүгнэлт санал зөвлөмж гаргасан.

- Нийт 83 тушаалын 178 заалтад холбогдох газруудаас биелэлтийг нөхөн гаргуулж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.
- Хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд бүрэн хэрэгжсэн 100% биелэлттэй 49 заалт, 70% биелэлттэй 24 заалт, 30% биелэлттэй 9 заалт байна.
- Гүйцэтгэх захирлын нийт 83 тушаал хяналтад байгаагаас

21 нь байнгын хяналтад байх дүрэм, журам, заавар, зөвлөмж, норм баталсан 12 нь байнгын ажиллагаатай хороо, ажлын хэсэг, комисс томилсон.

33 нь нэг удаагийн үүрэг даалгавар хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулснаас албан томилолтоор ажиллуулсан-1, зохион байгуулалтын арга хэмжээ авсан тушаал-12 байв.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Зам тээврийн хөгжлийн сайд, ТНБД-ын тушаалын нийт 40 биелэлтийг нэгтгэн ЗТХЯ-нд хугацаанд хүргүүлсэн. Үүнээс 2021 оны I улиралд 100% биелэлттэй 30 сайдын тушаал

70% биелэлттэй 7

30% биелэлттэй 1

Хугацаа болоогүй 2 биелэлт байсныг 2021 оны II улирлын биелэлтээр 70% биелэлттэй 6 тушаалыг шинэчлэн биелэлтийг 100%,

70%-ийн биелэлттэй тушаалыг 90%,

30% хувийн биелэлттэй 1 тушаалыг 70% биелэлттэйгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

## 7. Эрүүл ахуйн чиглэлээр:

Компанийн хэмжээнд эрүүл ахуйн чиглэлийн ажлууд хэвийн явагдаж байгаа ба он гарсанаас хойших хугацаанд Covid-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

- 1.Covid-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор 2020.11.10-наас 2021.05.25-ны өдрийн хооронд халдвараас хамгаалах худалдан авалт хийж төв оффис, төмөртэй өртөө тавантолгой зүүнбаян шинэ төмөр замын бүтээн байгуулалтын кеппүүдэд хуваарилалт хийж өгсөн байна. Үүнд халдвар хамгааллын цагаан хувцас, 1 удаагийн амны хаалт, спирт, гар ариутгагч санитас, нянгийн эсрэг гарын саван, ариутгалын бодис жавелин, халуун хэмжигч, бээлий зэрэг орсон болно.
- Халуун хэмжих төхөөрөмж, ухаалаг ариутгалын хэрэгслийг үүдний хэсэгт байршуулан иргэд болон ажилтны халууныг тогтмол үзэх, ариутгах, амны хаалт зүүх зөвлөмжийг өгч байна. Амны хаалт зүүгээгүй тохиолдолд дотогш нэвтрүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллаж байна.
- Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хүрээнд: Спиртэн суурьтай гар ариутгагчийг өрөө бүрт байршуулж, гараа тогтмол угааж ариутгаж байхыг зөвлөмж санамжуудыг байршуулсан.
- Ажилтнуудын биеийн халууныг хэвийн бус эсэх дээр өдөр бүр хяналт тавьж, тусгай зориулалтын халуун хэмжигчээр өдөрт 2 удаа тогтмол хэмжиж байна.
- Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан заавар зөвлөмжийн дагуу ажлын байранд мэргэжлийн байгууллага “Улаанбаатар ариутгал” компаниар 21 хоног тутам ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэж байгаа.
- Компанийн зүгээс ажилтнуудын дархлааг дэмжих зорилготойгоор дархлаа дэмжих бүтээгдэхүүн тарааж өгч байна.
- Улсын онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 39 дүгээр хурлын тэмдэглэлийн 2.1-т “Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшигаас хамгаалах бүх

- нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан төрийн захиргааны албан байгууллагын ажилтан, албан хаагчдын 10-15 хүртэлх хувийг ажлын байранд нь ажиллуулж, бусад ажилтнуудыг гэрээсээ цахимаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авах” гэж заасны дагуу гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дугаар сарын 04-ны өдрийн А/02 дугаар тушаалаар зайлшгүй нөхцөлд ажиллах ажилтны жагсаалтыг баталсан бөгөөд бусад ажилтнууд гэрээсээ цахимаар ажиллаж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж байна.
- Засгийн газар болон улсын онцгой комиссоос гаргаж буй тушаал шийдвэртэй уялдуулан гүйцэтгэх захирлын 2020.12.22-ны өдрийн А/304 дүгээр тушаал, 2021.01.05-ны өдрийн А/05 дугаар тушаал, 2021.01.08-ны өдрийн А/12 дугаар тушаалаар хариуцлагатай, эргүүл жижүүр томилон Covid-19 цар тахал болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангаж ажилласан бөгөөд гадны иргэнш дотогш нэвтрүүлэхгүй цахимаар харилцах боломжийг бүрдүүлэх, зайлшгүй нэвтрэх тохиолдолд биеийн халууныг хэмжих, иргэдийн байршлыг тогтоох зорилгоор QR код үүсгэн нэвтрэх хэсэгт байршуулах, тэмдэглэл хөтлөх халдвар хамгааллын дэглэмийг сахиулах болон бусад шаардлагатай арга хэмжээг бүх түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байна.
  - Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан тус компаниас олон нийтийн хэв журмыг сахиулахад 80 албан хаагчид Улаанбаатар хотод 2 ээлжээр 2021.02.11-22-ны өдрийн хооронд эргүүлээр ажиллаж бусад албан хаагчид халуун хоол цайгаар үйлчилж байсан.
  - Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2021-05-25 ны байдлаар нийт 304 ажилтнаас 1-р тун 192 хүн, 2-р тун 104 хүн нийт 296 хүнийг вакцинд хамруулж вакцинжуулалт 90 хувьтай байгаа ба Ковид тусаад эдгэрсэн 2 ажилтан, жирэмсэн 4 ажилтан, харшилтай 2 ажилтан вакцинд хамрагдаагүй болно.
  - Хөдөө орон нутагт ажиллаж байгаа албан хаагчид Цогтцэций болон Хүдэр суманд вакцинжуулалтанд хамрагдсан.
  - “COVID-19” цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа MNS ISO/PAS 45005:2021 стандарт нь 2021 оны 01 дүгээр сард батлагдсан ба тус стандартыг хэрэгжүүлэн хяналт тавих ажлыг 02 дугаар сарын 01-ний өдрийн захирлын А/13 дугаар тушаалаар баталсан. “Ажлын байранд коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх шалгах хуудас”-ын дагуу эрсдэлийн үнэлгээ хийж, түүнээс улбаалан тухайн байгууллагын хэмжээнд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхэд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулж “Ажлын байранд COVID-19 вирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө” гаргаж батлуулсан. Тус төлөвлөгөө нь цар тахлын үед тогтмол хэрэгжих ба 2,3,4,5,6 дугаар саруудад хийж гүйцэтгэх ажлуудыг төлөвлөсөн ба хэрэгжилтийн биелэлтийг 7 хоног бүр нэгтгэн удирдлагуудад танилцуулан ажиллаж байна.
  - УОК-ын 2021.03.13-ны өдрийн 8-р хурлын тэмдэглэлд заасны дагуу 70 хүртэлх хувийг цахимаар ажиллуулах талаар дотоод зохион байгуулалтыг хэрэгжүүлэн ажилласан.
  - Тус компанийн хэмжээнд Ковид-19 цар тахал болон ХАБЭА-н мэдлэг олгох сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж ажилласан.
  - УОК-ын дайчилгаанд 2021.04.01-ний өдрөөс эхлэн тодорхойгүй хугацаанд тус компаниас 1 жолооч 1 тээврийн хэрэгслийг гаргаж өгсөн ба өнөөдрийн байдлаар 1 жолооч ковид-19 өвчнөөр өвчилсөн өвчтөнүүдийг тээвэрлэх үйл ажиллагаанд оролцож байна.
  - Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан түр журамд заасан бүх нийтийн бэлэн байдлын зэрэг/Улаан түшин/-д шилжсэн үед 10 хувиар ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг баталж гарган хуваарийн дагуу ажиллаж байна.
  - УОК-оос гаргасан шийдвэрийн дагуу дархлаажуулалтын 2-р тунд хамрагдсан ажилчдыг ажиллуулах, мөн халдвар, хамгааллын дэглэмийг сайтар мөрдөж ажиллаж талаар нийт ажилтнуудад чиглэл өгч ажиллаж байна.
  - Дээд байгууллагаас ирүүлсэн чиглэлийн дагуу мэдээллийг тухай бүр цаг алдалгүй гарган өгч биелэлтийг нэгтгэн зам, тээврийн хөгжлийн яамны шуурхай штабын нарийн бичигт цахимаар хүлээлгэн өгч байна.
  - УОК-ын дайчилгаанд 2021.04.01-ний өдрөөс эхлэн тодорхойгүй хугацаанд тус компаниас 1 жолооч 1 тээврийн хэрэгслийг гаргаж өгсөн ба өнөөдрийн байдлаар 1 жолооч ковид-19 өвчнөөр өвчилсөн өвчтөнүүдийг тээвэрлэх үйл ажиллагаанд оролцож байна.

## 8. Хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр:

ХАБЭА тухай хуулийн 17 дугаар зүйл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 дугаар тушаалийн дагуу компанийн хэмжээнд нийт ажилтны сургалт, удирдах албан тушаалтны сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдөр мэргэжлийн сургалтын байгууллага болох Баянхүрээ сургалтын төвтэй хамтран зохион байгуулж шалгалт авч гарын үсэг зуруулан баталгаажуулсан.

Монгол улсад Ковид-19 /цар тахал/ гарсантай холбогдуулан танхимын сургалтуудыг хориглосон. Иймд "МТЗ" ТӨХК-ийн хэмжээнд ХАБЭА тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 заалтыг хүрээнд нийт

ажилтнуудын сургалтыг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр мэргэжлийн сургалтын төв болох "Баянхүрээ" сургалтын төвтэй хамтран цахимаар буюу ZOOM програмаар зохион байгуулж компанийн үндсэн гэрээтэй 100 ажилтан хамрагдсан. Компанийн харьяа Хянал шалгалтын газрын бие бүрэлдэхүүн галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил үүрэг гүйцэтгэдэг ажиллагсдад мэргэжлийн болон ХАБЭА сургалтын хөтөлбөр боловсруулж ХАБЭА чиглэлээр 12 цаг бүхийн 8 сэдвийн сургалт ZOOM програмаар зохион байгуулсан.

Компанийн хэмжээнд ХАБЭА дотоод хяналтыг Гүйцэтгэх захирлын 2021 оны 02 дугаар сарын 29-ны А/22а "Гурван шатны хяналтыг зохион байгуулах тухай" тоот тушаалаар зохион байгуулдаг. 1, 2 дугаар шатны хяналтыг өдөр бүр, 14 хоногт 1 удаа цех тасгийн ахлагч нар тогтмол зохион байгуулж илэрсэн зөрчил дутагдалыг цаг алдалгүй арилгуулж ХАБЭА ажилтан тогтмол хяналт тавьж 1,2 дугаар шатны хяналтын үзлэг хийсэн эсэх, сар бүр тогтмол тайлан авч ажиллаж байна.

Төмөртэй өртөө болон ТТ-ЗБ чиглэлийн шинэ төмөр замын бүтээн байгуулалтад ажиллаж буй галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтан алба хаагч нарыг өглөө ажилд гарах үед ерөнхий биеийн байдал даралт, согтууруулах ундаа хэрэгэлсэн эсэх дээр тогтмол хяналт тавьж бүртгэл хөтлөн ажиллаж байна. Илэрсэн зөрчил дутагдал дээр тухай бүр арга хэмжээ авч нийт ажилтнуудад анхааруулах арга хэмжээ зохиогдож байна.

Дэлхийн ХАБЭА өдрийг тохиолдуулан Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас "Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулья

- ХАБЭА тогтолцоог бэхжүүлбэ" уриан дор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аяныг 1 сарын хугацаатай зарласантай холбогдуулан компанийн хэмжээнд Гүйцэтгэх захирлын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/29 "Сарын аян зохион байгуулах тухай" тоот тушаал, хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлагдсан. Дээрх ажлын хүрээнд дараах ажлууд зохион байгуулагдсан. Үүнд:
- Нийт ажилтнууд дунд ХАБЭА танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн зохион байгуулсан.
- Хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах ажлын хүрээнд хоорондын замд ажилладаг замын хэсэгт зөөврийн саравч олгосон.
- ФБ цахим сүлжээнд Аюулгүй ажиллагаа миний амь насны баталгаа уриатай зурагаар давалгаалсан.
- Нийт ажилтнуудыг дархлаажуулах зориллогоор витамин, болон аарц олголт хийгдсэн
- Орц, гарц, хаалганд таних тэмдэгүүд хадаж байрлуулсан.
- Төмөртэй өртөө болон ТТ-ЗБ чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад ашиглагдаж байгаа нийт галын хоруудад тогтмол хяналт үзлэг хийгдэж дутуу, хор дууссан галын хорыг шуурхай цэнэглүүлж ажиллаж байна

## 9. ХШГ-аас зохион байгуулсан сургалтын чиглэлээр:

Төмөртэй өртөөний нийт ажилчдад ХШГ-ын даргын баталсан техникийн хичээлийн хөтөлбөрийн дагуу сургалтыг "Zoom" программ ашиглан чиглэл хариуцсан байцаагч нар цахим сургалтуудыг явууллаа.

### 1. Дохиолол, холбооны чиглэлээр:

Төмөртэй өртөөний дохиолол холбооны механикуудад батлагдсан хөтөлбөрийн дагуу

- Ахлах механикчийн эрх, үүрэг
- ДТХ байгууламжинд жил хийгдэх ажил "3.1 Зам төмөр хэлхээ" - ний туйлын солбицол шалгах. Техно-логийн карт №19, 20, 21, 22, 23, 24
- ДТХ байгууламжинд жил хийгдэх ажил "6.2 магистраль кабелийн өгөгдөл гаргах. Технологийн карт №36, 37, 38, 39
- ДТХ байгууламжинд жил хийгдэх ажил "2.4 Сум замналд орсон, сумын тусгаарлагдсан хэсэг хуу-рамч эзэлгээтэй үед сумыг шилжүүлэх боломжгүйг, тэлээ сум хоёр өөр байрлалд тавигдсан үед хяналт өгөгдөхгүй шалгах. Техно-логийн карт №4, 5, 6, 7
- ДТХ байгууламжинд жил хийгдэх ажил 15.1 Аянга сарниулагч ба хүчдэл тэгшитгэгчүүдийг шалгах Технологийн карт №47
- ДТХ байгууламжинд жил хийгдэх ажил 1.5 Хүлээн авах зам, замналд орсон тусгаарлагдсан хэсэг эзэл-гээтэй байхад оруулах гэрлэн дохио нээгдэхгүй байгаа шалгах. Технологийн карт №10
- 2-8сп, 4-6сп ЗТХ-ний тусгаарлах уулзварыг байрлуулж туйлын солбицолыг өнгөөр ялгаж зурах, тайлбарлах. Семинарын ажил
- Сумын 10 гэмтэл, Сумыг удирдах 4 утастын схем дээр ажиллах. Семинарын ажил

зэргээр сургалтыг цахимаар зохион байгуулсан.

Хичээл №2. Өртөөний зам төмөр хэлхээний байдал, тусгаарлагдсан хэсгийн тусгаарлалт ЗТХ-ний туйлын солбицол хэмжих, Туйлын солбицол буруу яаж гаргах тухай..

Хичээл №3 жилийн зурмаг: 2.4 Сум замналд орсон, сумын тусгаарлагдсан хэсэг хуурамч эзэлгээтэй үед сумыг шилжүүлэх боломжгүйг, тэлээ сум хоёр өөр байрлалд тавигдсан үед хяналт өгөгдөхгүй шалгах. Технологийн карт № 4, 5, 6, 7,

Хичээл №4 жилийн зурмаг: 1.5 Хүлээн авах зам, замналд орсон тусгаарлагдсан хэсэг эзэлгээтэй байхад оруулах гэрлэн дохио нээгдэхгүй байгаа шалгах. Технологийн карт №10.

Хичээл № 5 Сумын “10-н гэмтэл”-ийн тухай семинар хичээл орсон. Зам сум бодит байдалд судлаж, өөрийн болгох үүрэг өгсөн.

Хичээл № 6 Сумын 4 утастын схем: Ажлын ба хяналтын хэлхээ, БВС шулуутгагчийн үүрэг зориулалт. Схем унших аргачлал.

Хичээл № 7 ЗТХ: 2-8сп, 4-6сп ЗТХ-ний 2 утастын схем зурж, туйлын солбицол гаргах.

Хичээл № 8 ЗТХ-ний туйлын солбицол гаргах семинар: 2-8сп, 4-6сп зам төмөр хэлхээг зурж, туйлын солбицол гаргах явц: Хэрээс зам төмөр хэлхээний 2 утастын схемийг зурж, Туйлын солбицол гаргаж сурлаа.

## **2. Замын чиглэлээр:**

Төмөртэй өртөөний замын хэсгийн замчдад батлагдсан хөтөлбөрийн дагуу

- Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм
- Замын урсгал засвар арчлалтын журам
- Замын ажлыг гүйцэтгэх үед галт тэрэгний хөдөлгөөнийг хангах журмуудаас

нийт 14 сэдвээр 6 цагийн сургалтыг давхардсан тоогоор 64 ажилтанд цахимаар явуулсан.

## **3. Эрүүл ахуйн чиглэлээр:**

Хөтөлбөрт тусгагдсаны дагуу Төмөртэй өртөөний тогооч, бэлтгэгч нарт

- Эрүүл ахуйн хуулиас
- Тогооч бэлтгэгч нарын ажил үүрэг гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны талаар 4 цагийн цахим сургалтыг зохион байгуулж явууллаа.

## **4. Хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр:**

Монгол улсад Ковид-19 /цар тахал/ гарсантай холбогдуулан танхимын сургалтыг хориголсон. Иймд нийт ажилтнуудын ХАБЭА сургалтыг тасалдуулахгүйн тулд компанийн хяналт шалгалтын газрын бие бүрэлдэхүүн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр Төмөртэй өртөөний галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтан алба хаагч нарт цахим програм болох ZOOM програмаар хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө гарган зохион байгуулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр нийт 8 сэдвийн 12 цагийн сургалт зохион байгуулсан. Үүнд:

1. ХАБЭА тухай хууль
2. ҮОХХ судлан бүртгэх дүрэм 269 дүгээр тогтоол
3. Хөдөлмөрийн нөхцөл түүний ангилал
4. Галын аюулгүй байдлын сургалт
5. ХАБЭА тухай хууль ажилтны эрх үүрэг
6. Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, зохистой хэрэглээ
7. Хөдөлмөрийн тухай хууль
8. Ажлын байран дахь аюул эрсдэл түүний тухай ойлголт

Дээрх 8 сэдэв бүхий сургалт ZOOM програмаар зохион байгуулж бүртгэл хөтлөн ажилласан.

## **5. Хөдөлгөөн, ачаа тээврийн чиглэлээр:**

Батлагдсан хөтөлбөрийн дагуу Төмөртэй өртөөний ажилчдад 4 сэдвээр 6 цагийн сургалтыг “Zoom” программаар цахим сургалтыг зохион байгууллаа.

- Оворын тухай ойлголт
- Онцгой болгоомж шаардсан ачаатай вагон ба тусгай хөдлөх бүрэлдхүүнийг галт тэргэнд байрлуулах
- ГТХУЖ-ын 13 дугаар бүлэг
- ТЗДХЖ

## **11. ДҮГНЭЛТ**

Энэхүү тайлан нь “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2021 оны жилийн бүтээгдэхүүн нийлүүлэлт болон үйл ажиллагааны үр дүнг бүрэн, үнэн зөв илэрхийлсэн гэж үзэж байна.

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК